



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТАХ-г төлөвлөх, худалдан авах ажиллагаа зохион байгуулах, гүйцэтгүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага, албан тушаалтны хариуцлагагүйгээс зөрчлүүд дахин давтагдаж, төсвийн хөрөнгө арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулагдах нөхцөлийг бий болгож байна.



АУДИТЫН СЭДЭВ: ДҮҮРГИЙН ТӨСВИЙН 2021 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Улаанбаатар хот
2022 он

НТАГ-2022/16-11-ШТА-ГА

Аудитын тайланг бэлтгэсэн:	Товчилсон үг	2
Нийслэл дэх Төрийн аудитын газар	Хүснэгтийн жагсаалт	3
Аудитын III хэлтэс	Хавсралтын жагсаалт	3
Хэлтсийн дарга, аудитын менежер:	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	4
Э.Мөнхмандах		
Аудитын менежер:	Ерөнхий мэдээлэл	5
Л.Саранбаатар	А.Хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцоо үр нөлөөтэй эсэх	6
Аудитор:	Г.Чулуунцэцэг	
	А.1 Хөрөнгө оруулалтыг үр ашигтай төлөвлөх, зохистой арга хэмжээг авч байна уу?	6-8
	Ч.Чулуун-Эрдэнэ	
	А.2. Төсөл, арга хэмжээг үр ашигтай төлөвлөх тогтолцоог бүрдүүлж хэрэгжилтийг хангуулсан уу?	9-10
	О.Оргил	
	Б. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй эсэх.	10-11
Хаяг: УБ хот, Сүхбаатар дүүрэг, Соёлын Төв өргөө "Г" корпус, Утас: 11-327787	Б.1.Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулсан уу?	11-17
Тайланг НТАГ-ын http://www.audit.mn/ веб сайтаас үзнэ үү.	Б.2 Захиалагч гэрээний хэрэгжилтийг хугацаанд нь бүрэн хангуулж, хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн үү?	17-22
	Б.3 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт үр дүнтэй байна уу?	22-24
	Б.4 Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, зөрчлийг арилгуулсан уу?	24-25
	Аудитын дүгнэлт	26
	Аудитын зөвлөмж	27
	Хавсралтууд	28-45

Товчилсон үг

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БГД	Баянгол дүүрэг
БНД	Багануур дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг
БТХ	Бодлого төлөвлөлтийн хэлтэс
ДИТХ	Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ЗГ	Засгийн газар
ЗД	Засаг дарга
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
НАЗХГ	Нийслэлийн авто замын хөгжлийн газар
НХААГ	Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар
НХОГ	Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар
НҮТББ	Нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллага
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СБД	Сүхбаатар дүүрэг
СХД	Сонгинохайрхан дүүрэг
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТББ	Тендерийн баримт бичиг
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХААА	Худалдан авах ажиллагааны алба
ХАБЭА	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
ХУД	Хан-Уул дүүрэг
ЧД	Чингэлтэй дүүрэг
ЭЗТХ	Эдийн засаг, төлөвлөлтийн хэлтэс

Хүснэгтийн жагсаалт

Дугаар	Гарчиг	Хуудас
Хүснэгт 1	2020, 2021 онд хэрэгжүүлэхээр баталсан ТАХ-ний харьцуулалт	5
Хүснэгт 2	Шинээр төлөвлөсөн ТАХ-г ангилсан байдал	6
Хүснэгт 3	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн дунд болон богино хугацааны баримт бичгүүдтэй уялдаагүй ТАХ-ний тоо	7
Хүснэгт 4	Харьяа байгууллагуудаас ирүүлсэн саналыг тусгасан эсэх	7
Хүснэгт 5	2021 онд хэрэгжих ТАХ-г салбараар эрэмбэлсэн байдал	8
Хүснэгт 6	Зураг төсөв боловсруулаагүй батлуулсан ТАХ	9
Хүснэгт 7	Тухайн онд санхүүжих дүнг дутуу баталсан ТАХ	10
Хүснэгт 8	Худалдан авах ажиллагаа зохион байгуулсан ТАХ	11
Хүснэгт 9	Эрх шилжүүлэх захирамжгүй ХАА зарласан ТАХ	12
Хүснэгт 10	ТАХ-ний эрхийг шилжүүлэхэд зарцуулсан хугацаа	12
Хүснэгт 11	Үнэлгээний хороо байгуулахад зарцуулсан хугацаа	12
Хүснэгт 12	Худалдан авах ажиллагаа зохион байгуулсан журам	13-14
Хүснэгт 13	Тендерийн баримт бичигт заасан нөхцөл хангаагүй гүйцэтгэгч шалгаруулсан	16
Хүснэгт 14	Гүйцэтгэлийн шатанд баталгаажуулсан актууд	21
Хүснэгт 15	ТАХ-ний санхүүжилтийн судалгаа	22-23
Хүснэгт 16	2021 онд хэрэгжсэн ТАХ-нд олгосон санхүүжилт барьцаа, алданги	23
Хүснэгт 17	Хөрөнгө бүртгэлийн судалгаа	24
Хүснэгт 18	Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын биелэлт	24

Графикийн жагсаалт

Дугаар	Гарчиг	Хуудас
График 1	Шинээр төлөвлөсөн ТАХ-ны тоо	6
График 2	ТАХ-нд эзлэх ажлын төрөл	11

Хавсралтын жагсаалт

Дугаар	Гарчиг	Хуудас
Хавсралт 1	Засаг даргын мөрийн хөтөлбөр, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгаагүй ТАХ	28
Хавсралт 2	Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл-д тусгаагүй ТАХ	28-29
Хавсралт 3	Зураг төсөв боловсруулаагүй батлуулсан ТАХ	29-30
Хавсралт 4	Хөрөнгө оруулалтын шинж чанартай бус ТАХ	31
Хавсралт 5	ХАА зохион байгуулахад үйл ажиллагаатай холбоотой гарсан зөрчил	31-38
Хавсралт 6	Төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагаатай холбоотой гарсан зөрчил	38-45

<p>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх</p>	<p>Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл</p> <p>Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны 06 дугаар тогтоол, МУЕА-ын 2022 оны А/12 дугаар тушаалыг үндэслэн хийв.</p>
<p>Аудитын зорилт</p>	<p>Аудитын зорилт Дүүргийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт аудит хийж дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд чиглэгдсэн.</p> <p>Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none">✚ Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт үр дүнтэй эсэх✚ Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй эсэх
<p>Аудитын хамарсан хүрээ</p>	<p>Аудитыг дүүргүүдийн ЗДТГ-ын СТСХ, ЭЗТХ, Дэд бүтэц, тохижилтын хэлтэс, Худалдан авах ажиллагааны албадыг хамруулан гүйцэтгэлээ.</p>
<p>Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт</p>	<p>Аудитыг АДБОУС 300, 3000-3100 үндэслэн боловсруулсан гүйцэтгэлийн аудитын журмыг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага хийх, асуулга, судалгаа авах, мэдээ, тайланг судалж, санхүүгийн тайлангийн болон нөхцөл байдлын шинжилгээ хийх зэргээр аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, ажлын баримт боловсруулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.</p>
<p>Аудитын бүрэлдэхүүн, хугацаа</p>	<p>Аудитыг 3 дугаар хэлтсийн дарга, аудитын менежер Э.Мөнхмандах хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Л.Саранбаатар хэрэгжүүлж, Аудитор Г.Чулуунцэцэг ахлан, аудитор Ч.Чулуун-Эрдэнэ, О.Оргил нар гүйцэтгэв.</p>

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Дүүргүүдийн ИТХ-аар Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар өмнөх онуудаас дамжин хэрэгжсэн болон 2021 онд шинээр хэрэгжих нийт 89,586.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 275 ТАХ-г баталжээ. /8 дүүргийн хэмжээнд, НД-т Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар ТАХ хэрэгжээгүй/

Эдгээр 275 ТАХ-ээс 55,467.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 214 ТАХ нь 2021 онд шинээр хэрэгжих, 34,119.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 61 ТАХ нь өмнөх онуудаас дамжин хэрэгжсэн байна.

Шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 214 ТАХ-ээс 2021 онд 210 ТАХ-нд ХАА-г зохион байгуулахаар төлөвлөсөн ч төсөв, ажлын даалгаваргүй, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулаагүй, тендер зохион байгуулах ажил явагдаж байгаа зэргээс шалтгаалан 58 ТАХ-ний ХАА тухайн онд хэрэгжээгүй байна.

Өмнөх оноос дамжин хийгдсэн болон 2021 онд шинээр эхэлсэн нийт 78,558.7 сая төгрөгийн гэрээний дүнтэй 250 ТАХ-нд дүүргүүдийн ЗДТГ болон “НХОГ” ОНӨААТҮГ, НАЗХГ, “Хүн төвтэй хот төлөвлөлтийн лаборатори” НҮТББ, СХД-ын Захиалагчийн алба зэрэг газрууд захиалагчийн хяналт хэрэгжүүлжээ.

2021 онд 23,858.0 сая төгрөгийн дүнтэй 168 ТАХ хэрэгжиж дууссан, 54,700.7 сая төгрөгийн дүнтэй 82 ТАХ хэрэгжилт дутуу 2022 онд үргэлжлэн хэрэгжиж байгаа, харин 2,092.7 сая төгрөгийн дүнтэй 2 ТАХ газрын болон шүүхийн маргаантай хэрэгжээгүй байна.

Дүүргүүдийн ТАХ-ны батлагдсан тоо өмнөх онтой харьцуулахад 70 ТАХ-ээр буурсан ч төсөвт өртөг 4,563.1 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь ТАХ-ны цар хүрээ, эдийн засгийн нөхцөл байдалтай холбоотой байна.

Хүснэгт 1. 2020, 2021 онд хэрэгжүүлэхээр баталсан ТАХ-ний харьцуулалт

№	Дүүргийн нэр	2020 он		2021 он		Өсөлт, бууралт /сая.төг/	
		Баталсан ТАХ тоо	Төсөвт өртөг	Баталсан ТАХ тоо	Төсөвт өртөг	ТАХ тоо	Төсөвт өртөг
1	БГД	35	8,654.10	44	16,023.40	-9	-7,369.30
2	БЗД	45	5,313.30	12	4,542.74	33	770.56
3	БНД	21	441	35	1,015.56	-14	-574.56
4	БХД	3	33.1	6	162.13	-3	-129.03
5	СБД	116	35,893.50	58	31,765.50	58	4,128.00
6	СХД	29	4,623.80	20	5,820.70	9	-1,196.90
7	ЧД	22	8,024.60	32	20,761.80	-10	-12,737.20
8	ХУД	74	22,040.20	68	9,494.86	6	12,545.34
	Нийт	345	85,023.60	275	89,586.69	70	-4,563.09

Аудитын түүврийг хийхдээ МУЕА-ын 2018 оны А/351 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Гүйцэтгэлийн аудитад түүвэрлэлтийг ашиглах” зааврын дагуу эх олонлогийг бүхэлд нь хамруулах үүднээс 2021 онд хэрэгжсэн ТАХ-ний төсөвт өртөг болон төрөл тус бүрээс хамруулсан. Үүнд:

- 2021 онд шинээр төлөвлөгдсөн 55,467.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 214 ТАХ-г бүрэн хамруулсан;
- Худалдан авалт зохион байгуулсан 37,271.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 152 ТАХ-г бүрэн хамруулсан;
- Гэрээний хэрэгжилт: 2021 онд 85%-с дээш гүйцэтгэлтэй, санхүүжилт олгосон 25,471.6 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 178 ТАХ-ээс 81.5% буюу 145-г түүвэрт хамруулсан;
- Шинээр болон он дамжин хэрэгжих 65,129.8 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 178 ТАХ-ний санхүүжилт, барьцаа хөрөнгө, хүү алданги торгууль, техникийн болон захиалагчийн хяналтын зардлыг 100% тулган баталгаажуулсан.

БҮЛЭГ 1. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН ТОГТОЛЦОО ҮР НӨЛӨӨТЭЙ ЭСЭХ

А.1 Хөрөнгө оруулалтыг үр ашигтай төлөвлөх, зохистой арга хэмжээг авч байна уу?

Төсвийн тухай хуулийн 12.1.4¹, 6.5², 67.3³ дахь заалтыг мөрдлөг болгож “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Дүүргүүдийн 3Д-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хүрээнд дүүргүүд 2021 оны төсвөө баталжээ.


2021 онд 55,467.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 214 ТАХ шинээр хэрэгжүүлэхээр баталсан.

Хүснэгт 2. Шинээр төлөвлөсөн ТАХ-г ангилсан байдал

№	Ангилал	Тоо	Төсөвт өртөг	/сая.төг/ Эзлэх хувь
1	Барилга, барилгын засвар	49	26,356.35	22.9%
2	Дэд бүтэц	12	3,086.3	5.6%
3	Зам, замын засварын үйлчилгээ	4	2,038.2	1.9%
4	Зураг төсөв	44	3,114.9	20.6%
5	Машин, тоног төхөөрөмж	17	6,250.6	7.9%
6	Тоног төхөөрөмж	41	5,314.0	19.2%
7	Тохижилт	46	8,706.6	21.5%
8	Бусад	1	600.0	0.5%
	Нийт	214	55,467.1	100%

2021 онд хэрэгжүүлэх ТАХ хэрэглэгчийн хэрэгцээ шаардлага, олон нийтийн саналд үндэслэсэн ч хөгжлийн бодлого төлөвлөлтийн дунд болон богино хугацааны баримт бичигтэй бүрэн уялдуулаагүй, эрэмбэ, дарааллыг баримтлах арга хэмжээ хангалтгүй байна.

График 1. Шинээр төлөвлөсөн ТАХ-ний тоо



¹12.1.4.жилийн төсвийн төсөл боловсруулах удирдамжийг төсвийн цаглабрыг баримтлан бэлтгэж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх;

² 6.5.Энэ хуулийн 5.1.4-т заасан төсвийн ил тод байдлыг хангасан байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

³ 67.3.Аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн төслийг боловсруулах явцдаа төслийг тухайн шатны Засаг дарга олон нийтэд танилцуулж, тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн санал, хүсэлтийг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулна.

А.1.1. Төсөл, арга хэмжээг хөгжлийн бодлого төлөвлөлтийн дунд болон богино хугацааны баримт бичгүүдтэй уялдуулан төлөвлөсөн үү?

2021 онд шинээр хэрэгжүүлэхээр баталсан 214 ТАХ-г хөгжлийн бодлого төлөвлөлтийн дунд болон богино хугацааны баримт бичгүүдтэй уялдсан эсэхийг тулган баталгаажуулахад дараах байдалтай байна. Үүнд:

- Дунд хугацааны баримт бичиг: “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д 187 буюу 87.4%, “Дүүргүүдийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т 189 буюу 88.3% ТАХ нь туссан байна.
- Богино хугацааны баримт бичиг: Дүүргүүдийн ЗД-ын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухайн жилийн төлөвлөгөөнд 189 буюу 88.3% ТАХ нь туссан байна. *Хавсралт 1, 2.*

Хүснэгт 3. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн дунд болон богино хугацааны баримт бичгүүдтэй тусгагдаагүй ТАХ-ний тоо

№	Дүүргийн нэр	Нийт ТАХ-ний тоо	Үүнээс		Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан эсэх	
			Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан эсэх			
			Тоо	Тоо	Тоо	Тоо
1	БЗД	5	5			
2	БГД	31	21		2	
3	СХД	10	2		2	
4	СБД	28	4		-	
5	ХУД	32	3		3	
6	ЧД	68	-		14	
7	БНД	34	-		-	
8	БХД	6	-		4	
	<i>Нийт</i>	214	35		25	

Дүгнэлт: 2021 онд хэрэгжихээр батлагдсан 214 ТАХ-нээс хөгжлийн бодлого төлөвлөлтийн дунд болон богино хугацааны баримт бичгүүдэд 87.4-88.3%-нь тусгагдсан байна.

А.1.2. Жагсаалтад батлагдсан ТАХ-г хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад үндэслэсэн үү?

Дүүргүүд 2021 оны төсөв, хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-ний төлөвлөгөөг боловсруулах ажлын хүрээнд санал авахад харьяа байгууллагуудаас 687, хороод болон иргэдээс 1502, нийт 2189 санал ирүүлсэн байна. Үүнээс шинээр хэрэгжүүлэхээр баталсан 214 ТАХ-г арга хэмжээ тус бүрээр судалж үзэхэд ирүүлсэн саналуудад үндэслэсэн байна.

Хүснэгт 4. Харьяа байгууллагуудаас ирүүлсэн саналыг тусгасан эсэх /тоогоор/

№	Дүүргийн нэр	Хороод /Иргэд/		Харьяа байгууллагаас		Нийт	
		Ирүүлсэн	Төсөвт тусгагдсан	Ирүүлсэн	Төсөвт тусгагдсан	Ирүүлсэн	Төсөвт тусгагдсан
1	БЗД	39	1	28	4	67	5
2	БГД	414	21	39	10	453	31
3	СХД	188	1	7	7	195	8
4	СБД	511	18	153	2	664	20
5	ХУД	93	13	23	5	116	18
6	ЧД	90	8	265	10	355	18
7	БНД	41	9	165	25	206	34
9	БХД	126	1	7	4	133	5
	<i>Нийт</i>	1502	72	687	67	2189	139

Дүгнэлт: 2021 онд шинээр хэрэгжүүлэхээр баталсан ТАХ-г хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад үндэслэсэн байна.

А.1.3. ТАХ-ны ач холбогдлын эрэмбэ, хэрэгжүүлэх дарааллыг олон нийтийн саналд үндэслэсэн үү?

2021 онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 214 ТАХ-ний ач холбогдлын эрэмбэ, хэрэгжүүлэх дарааллыг олон нийтийн саналд үндэслэсэн эсэхийг тулган баталгаажуулахад дараах байдалтай байна. Үүнд:

- БГД, БЗД, СБД, БНД зэрэг дүүргүүд нь Нийслэлийн Засаг даргын 2020 оны 01 сарын 07-ны өдрийн А/11 тоот захирамжаар 2021 онд хэрэгжүүлэх ТАХ-ний саналыг олон нийтээс авах ажлыг 2020 оны эхний улиралд зохион байгуулж, ИТХ-аараа хэлэлцүүлэн эрэмбэлсэн байна.

Сангийн сайдын 2018 оны 295 тоот тушаал баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.4⁴, 4.5⁵, 5 дугаар зүйлийн 5.10⁶-д заасны дагуу ТАХ-г эрэмбэлэхдээ өмнөх оноос хэрэгжсэн ТАХ, их засвар, шинээр хэрэгжүүлэх ТАХ гэсэн дарааллаар, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, тэргүүлэх чиглэлийн төслүүд байх гэсэн үзүүлэлтийг харгалздаг байна.

Дээрх 4 дүүрэгт 2021 онд хэрэгжих 49,684.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 149 ТАХ-г аудитаар эрэмбэлсэн эсэхийг тулгахад дараах байдалтай байна.

Хүснэгт 5. 2021 онд хэрэгжих ТАХ-г салбараар эрэмбэлсэн байдал

/сая.төг/

№	Дүүргийн нэр	Ангилал	Шилжих болон шинэ	Төсөвт өртөг	Эзлэх хувь
1		Барилга, барилгын засвар	Шилжих	24,837.2	50.0
			Шинэ	9,254.0	18.6
2		Дэд бүтэц	Шилжих	74.3	0.1
			Шинэ	240.3	0.5
3		Зам, замын засварын үйлчилгээ	Шилжих	1,474.2	3.0
			Шинэ	862.0	1.7
4	БГД, БЗД, СБД, БНД	Зураг төсөв	Шилжих	1,725.1	3.5
			Шинэ	1,464.2	2.9
5		Машин, тоног төхөөрөмж	Шилжих	745.0	1.5
			Шинэ	2,695.0	5.4
6		Тохижилт	Шилжих	1,926.0	3.9
			Шинэ	3,787.5	7.6
7		Бусад	Шилжих	-	0.0
			Шинэ	600.0	1.2
НИЙТ				49,684.9	100.0

Эрэмбэлсэн байдлыг судлахад 30,781.8 сая төгрөг буюу 61.9% нь өмнөх онуудаас хэрэгжсэн ТАХ, 18,903.1 сая төгрөг буюу 38.1% нь барилга, барилгын засвар болон бусад хөрөнгө оруулалтын ажлууд байна.

- Харин ЧД, ХУД, СХД, БХД-үүд нь ТАХ-ний ач холбогдлын эрэмбэ, дарааллыг хэрэгжүүлээгүй, Төсвийн тухай хуулийн 6.5.5⁷, 67.3⁸ дахь заалтуудыг зөрчсөн байна.

Дүгнэлт: БГД, БЗД, СБД, БНД-үүд нь 2021 онд хэрэгжүүлэх ТАХ-г олон нийтийн саналд үндэслэн ач холбогдол, эрэмбэ, дарааллыг баримтлан төсөвт тусгасан, ЧД, ХУД, СХД, БХД-үүд ТАХ-ний ач холбогдлын эрэмбэ, дарааллыг хэрэгжүүлээгүй байна.

⁴ 4.4 Төсвийн төсөлд тусгах төслийг сонгох болон төслийн санхүүжилтийг шийдвэрлэхдээ дараах эрэмбийг баримтлана. Үүнд:

⁵ 4.5 Төсөл нь холбогдох Аргачлалд заасны дагуу шалгуур үзүүлэлтээр үнэлэгдсэн, эдийн засгийн үр ашигтай нийгмийн ач холбогдолтой, тэргүүлэх зэрэглэлийн төслүүд байна.

⁶ 5.10. Сангийн яам, Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар нь төсөвт тусгах хөрөнгө оруулалтын төслийг тодорхойлж, шийдвэрлэхдээ энэхүү журмын 4.4-т заасан эрэмбийг баримтлах үүрэгтэй;

⁷ 6.5.5.хөтөлбөр, төсөл, арга хэмжээний ач холбогдлын эрэмбэ, хэрэгжүүлэх дараалал, арга замыг тодорхойлох шийдвэрт олон нийтийн саналыг харгалзан үзэх;

⁸ 67.3.Аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн төслийг боловсруулах явцдаа төслийг тухайн шатны Засаг дарга олон нийтэд танилцуулж, тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн санал, хүсэлтийг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулна.

А.2 Төсөл, арга хэмжээг үр ашигтай төлөвлөх тогтолцоог бүрдүүлж хэрэгжилтийг хангуулсан уу?

Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөхдөө Төсвийн тухай хуульд заасан төсөвлөлтийн шаардлагыг хангуулаагүй, хугацаандаа хэрэгжих боломжгүй, хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төсөл, арга хэмжээг төлөвлөжээ.

А.2.1. Шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө төсөвлөлтийн шаардлагыг хангуулсан уу?

Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжүүлэхээр баталсан 214 ТАХ-ээс зураг төсөв шаардлагатай 102 ТАХ байна. Үүнээс 20,306.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 60 ТАХ буюу 58.8%-ийг зураг төсөвгүй баталсан байна. Тухайлбал:

- ХУД-т хэрэгжих Хороо, эрүүл мэндийн төвийн цогцолбор барилга /15-р хороо/, төсөвт өртөг 1,500.0 сая төгрөг;
- БГД-т хэрэгжих Нийтийн эзэмшлийн зам талбайн гэрэлтүүлэг суурилуулах ажил, төсөвт өртөг 665.0 сая төгрөг;
- ЧД-т хэрэгжих Хайлаастын замаас Хайлаастын эцэс хүртэл авто зам, төсөвт өртөг 976.2 сая төгрөг;
- СБД-т хэрэгжих 2 дугаар хороо, 2 дугаар хорооны ӨЭМТ, цагдаа, хорооны ажлын албаны нэг цэгийн үйлчилгээний байр шинээр барих нэмэлт санхүүжилт, төсөвт өртөг 384.0 сая төгрөг.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4⁹ дэх заалтуудыг тус тус зөрчжээ. *Хавсралт 3.*

Хүснэгт 6. Зураг төсөв боловсруулаагүй батлуулсан ТАХ

№	Дүүргийн нэр	Зураг төсөв шаардлагатай ТАХ	/сая.төг/	
			Үүнээс зураг төсөвгүй Тоо	Төсөвт өртөг
1	БГД	17	12	3,144.0
2	СБД	24	2	624.0
3	ХУД	24	11	10,334.4
4	ЧД	35	35	6,204.0
	Нийт	102	60	20,306.4

ТАХ-г төлөвлөхдөө холбогдох хууль тогтоомжид заасны дагуу төсөвлөлтийн шаардлага хангаагуулаагүй ТАХ-г тусгаж байгаа нь тогтоолоор баталсан дэд бүтэц, тохижилт зэрэг бүтээн байгуулалтын ажлууд төлөвлөсөн хугацаандаа хэрэгжихгүй, он дамжих зэрэг үр дагавар үүсэж байна.

Дүгнэлт: Шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө төсөвлөлтийн шаардлагыг хангуулаагүй нь ТАХ-ний хэрэгжилт удаашрахад нөлөөлж байна.

А.2.2. Төсөл, арга хэмжээг хугацаандаа хэрэгжих боломжтой байдлаар тооцож, санхүүжилтийг батлуулсан уу?

Дүүргүүд тухайн онд хэрэгжүүлэх 77,586.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 270 ТАХ-г батлахдаа дээрх заалтыг хэрэгжүүлсэн байна.

⁹ 29.4.Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

Харин ХУД-ийн төсвийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх 12,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 ТАХ-ний тухайн онд санхүүжих дүнг 200.0-400.0 сая төгрөгөөр дутуу, нийт 1,200.0 сая төгрөгөөр дутуу баталжээ.

Хүснэгт 7. Тухайн онд санхүүжих дүнг дутуу баталсан ТАХ

№	ТАХ-ний нэр	Хэрэгжих хугацаа		Батлагдсан		Санхүүжих дүнгийн зөрүү	
		Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тэнцүү хуваарилсан дүн	Зөрүү
1	Цэцэрлэгийн барилга, 4-р хороо /200 ор/	2021	2021	2,400.00	1,000.00	1,200.00	-200
2	Цэцэрлэгийн барилга, 15-р хороо /200 ор/	2021	2021	2,400.00	1,000.00	1,200.00	-200
3	Цэцэрлэгийн барилга, 16-р хороо	2021	2021	2,400.00	1,000.00	1,200.00	-200
4	Хороо, өрхийн эрүүл мэндийн төвийн цогцолбор барилга, 15-р хороо	2021	2021	2,600.00	900	1,300.00	-400
5	Хороо, өрхийн эрүүл мэндийн төвийн цогцолбор барилга, 21-р хороо	2021	2021	2,200.00	900	1,100.00	-200
	Нийт			12,000.00	4,800.00	6,000.00	-1200

Дүгнэлт: Дүүргүүд ТАХ-г хугацаандаа хэрэгжих боломжтой байдлаар тооцож, санхүүжилтийг батлуулжээ.

А.2.3. Хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төсөл, арга хэмжээг төлөвлөж, батлуулсан уу?

2021 онд шинээр хэрэгжих 55,467.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 214 ТАХ-ээс 3,914.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 22 ТАХ буюу 10.3% нь төрийн өмчийн болон төрийн өмчит байгууллагуудад бүртгэгдэхгүй хөрөнгө оруулалтын бус шинж чанартай ажлууд байна. *Хавсралт 4.* Тухайлбал:

- БЗД-т хэрэгжих Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа, газар ашиглалт болон орчны бохирдолд судалгаа хийх ажил, төсөвт өртөг 600.0 сая төгрөг;
- БГД-т хэрэгжих /насжилт бага/ Нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шат шинэчлэл, төсөвт өртөг 500.0 сая төгрөг;
- СБД-т хэрэгжих 3 дугаар хороо, 14а дугаар байрны дээвэр засвар, төсөвт өртөг 121.8 сая төгрөг;
- ХУД-т хэрэгжих Нийтийн зориулалттай орон сууцны засвар, төсөвт өртөг 260.0 сая төгрөг;
- ЧД-т хэрэгжих 2 дугаар хорооны 21-р байрны фасад засвар, төсөвт өртөг 175.0 сая төгрөг.

Дүгнэлт: Хөрөнгө оруулалтын шинж чанартай бус зарим төсөл, арга хэмжээг төлөвлөж, баталсан нь нийт ТАХ-ний 10,3 хувь байна.

Б. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮНТЭЙ ЭСЭХ

Б.1 Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулсан уу?

2021 онд худалдан авахаар төлөвлөсөн нийт 89,586.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 275 ТАХ-ээс 225 ТАХ-нд ХАА зохион байгуулж, үүнээс 40,088.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 167 ТАХ-ний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулжээ.


Хүснэгт 8. Худалдан авах ажиллагаа зохион байгуулсан ТАХ

№	Эрх шилжсэн байгууллага	ХАА зохион байгуулсан ТАХ				ХАА амжилттай зохион байгуулсан ТАХ			
		Захирамж	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Шалгарсан өртөг	Хэмнэлт
1	БГД	1	19	4,608.1	4,608.1	19	4,608.1	3,853.5	754.6
2	БЗД	0	12	4,542.7	1,138.3	9	1,247.7	1,092.7	155.0
3	БНД	10	10	555.6	240.3	5	246.3	240.3	6.0
4	БХД	0	2	135.4	135.4	2	135.4	134.9	0.5
5	СБД	8	54	5,999.6	5,227.6	48	5,227.6	4,725.8	501.8
6	СХД	12	16	3,109.8	1,820.3	16	3,109.8	3,023.7	86.1
7	ХУД	6	43	24,760.7	14,603.1	33	21,403.1	20,638.3	764.9
8	ЧД	10	69	9,567.1	4,110.7	35	4,110.7	3,885.1	225.6
	Нийт	47	225	53,279.0	31,883.8	167	40,088.8	37,594.4	2,494.4

2021 онд 13,190.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 58 ТАХ дараах байдлаар хэрэгжиж дуусаагүй байна. Үүнд:

- 7,348.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 21 ТАХ он дамжин зарлагдаж байгаа;
- 4956.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 26 ТАХ нь зураг төсөв, ажлын даалгаваргүй тул цуцлагдсан;
- 765.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 ТАХ-ны үнэлгээ хийгдэж байгаа;
- 120.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 ТАХ-нд шууд гэрээ хийх мэдэгдэл хүргүүлсэн.

График 2. ТАХ-нд эзлэх ажлын төрөл



ТАХ-г төрлөөр нь авч үзвэл барилга, барилгын засвар, орчны тохижилт 53.3%, машин, техник, тавилга тоног төхөөрөмж 21.8%, зураг төсөл боловсруулах, зөвлөх үйлчилгээ 20.0%, авто замын барилга байгууламж, өргөтгөл, шинэчлэлт, засвар, гүүр хоолой, тэмдэг тэмдэглэгээ 4.9%-ийг эзэлж байна.

Зарим дүүргүүд ХАА-г зарлахдаа эрх шилжүүлсэн захирамжийг үндэслэл болгоогүй, ХАА зарласан ТАХ-ний 74.2%-д нь гэрээ байгуулагдсан боловч 37.1%-д нь шаардлага хангаагүй гүйцэтгэгч сонгон шалгаруулсан, ТАХ-үүдийг тайлагнасан ч зарим тоон мэдээг зөрүүтэй, дутуу илэрхийлсэн байна.

Б.1.1. Төсөл, арга хэмжээг хэрэгжих боломжтой хугацаанд эрх шилжүүлсэн үү?

Дүүргүүдийн хэмжээнд 53,279.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 225 ТАХ-г хэрэгжүүлэхээр 2021 онд 2-4 удаагийн тогтоолоор тодотгол оруулан баталжээ. Үүнээс 38,264.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 166 ТАХ-г дүүргүүдийн ЗД-аас эрх шилжүүлж ХАА зарлахыг захирамжилсан бол 31,945.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 59 ТАХ-г дүүргийн ЗД-ын захирамжгүй зарлажээ.

Энэ нь Сангийн сайдын 2017 оны 363 тоот тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах

ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 2.13¹⁰-т эрх шилжүүлэх хугацааг төсөв батлагдсанаас хойш 60 хоногийн дотор, тодотгол орсон бол түүнээс хойш 30 хоногийн дотор тус тус холбогдох албан тушаалтанд шилжүүлсэн байхаар заасныг зөрчсөн байна.

Хүснэгт 9. Эрх шилжүүлэх захирамжгүй ХАА зарласан ТАХ

№	Эрх шилжүүлэх газар	/сая төг/				
		Эрх шилжүүлэх ТАХ-ны Тоо	Төсөвт өртөг	Эрх шилжиж ирээгүй ТАХ-ны Тоо	Төсөвт өртөг	Хувь
1	БГД ЗД	19	4,608.1	8	2,830.0	42.1
2	БЗД ЗД	12	4,433.3	12	4,542.7	100
4	БХД ЗД	2	135.4	2	135.4	100
7	ХУД ЗД	43	16,560.7	37	24,437.4	86
	Нийт	76	25,737.4	59	31,945.5	

Захирамжаар эрх шилжиж ХАА зарлагдсан 166 ТАХ-ээс 86-ааг 0-60 хоногт эрх шилжүүлсэн, 80-ийг 60-аас дээш хоногийн дараа эрхийг шилжүүлсэн байна.

Хүснэгт 10. ТАХ-ний эрхийг шилжүүлэхэд зарцуулсан хугацаа

№	Эрх шилжсэн	0-30 хоногт	30-60 хоногт	60-90 хоногт	90-ээс дээш хоногт	Нийт
1	БГД ХААА	11	-	-	-	-
2	БЗД ХААА	-	-	-	-	-
3	БНД ХААА	10	-	-	-	-
4	БХД ХААА	-	-	-	-	-
5	СБД ХААА	-	-	36	18	-
6	СХД ХААА	10	-	1	5	-
7	ХУД ХААА	6	-	-	-	-
8	ЧД ХААА	49	-	20	-	-
	Нийт	86	-	57	23	166

Дүүргүүдийн ЗД нар хугацаа алдаж эрх шилжүүлсэн нь ТАХ хэрэгжих боломжтой хугацаандаа хэрэгжихгүй байх, улирлын шинж чанартай ажлууд хойшлогдох үр дагавартай байна.

Дүгнэлт: Зарим дүүргүүд ЗД эрх шилжүүлээгүй байхад ХАА-г зохион байгуулсан, эрх шилжүүлсэн ТАХ-ний 48.2%-ийг нь хугацаа хэтрүүлж шилжүүлсэн байна.

Б.1.2. ТАХ-г тайлант онд бүрэн хэрэгжих боломжийг хангахуйцаар ХАА-г зохион байгуулсан уу?

Дүүргийн ЗД нараас эрх шилжиж ирсэн 166 ТАХ-ээс 34.3% буюу 57 ТАХ нь 60-90 хоногт, 13.9% буюу 23 ТАХ нь 90-ээс дээш хоног буюу нийт хугацаагаар авч үзэхэд үнэлгээний хороо байгуулахад эрх шилжиж ирсэн өдрөөс хойш 1-297 хүртэл хоног зарцуулжээ.

Хүснэгт 11. Үнэлгээний хороо байгуулахад зарцуулсан хугацаа

		/сая.төг/	
	Хугацаа	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг
1	0-30 хоногт	86	12,527.20
2	30-60 хоногт	0	0
3	60-90 хоногт	57	6,414.20
4	90-ээс дээш	23	2,392.10
	Нийт	166	23,333.30

¹⁰ 2.13.Захиалагч хуулийн 46.3-т заасны дагуу эрх шилжүүлэх тохиолдолд төсөв батлагдсанаас хойш 60 хоногийн дотор,хэрэв тодотгол орсон бол түүнээс хойш 30 хоногийн дотор тус тус холбогдох албан тушаалтанд шилжүүлсэн байх.

Үнэлгээний хороог 60-аас дээш хоногт байгуулсан нь захиалагчаас Төсвийн тухай хуулийн 29.4¹¹, ТБОНӨХБАҮХАТХ-ийн 48.3¹²-т заасан үүргээ биелүүлээгүй, холбогдох баримт материалыг дүүргүүдийн ХААА-дад хууль тогтоомжид заасан хугацаанд хүргүүлээгүй зэргээс шалтгаалж байна. Тухайлбал: СБД, СХД, ЧД-үүд нь 80 ТАХ-тэй холбоотой ажлын техникийн тодорхойлолт, зураг төсөл, ажлын даалгавар болон бусад шаардлагатай мэдээллийг хугацаа хоцроож хүргүүлсэн байна.

Зураг төсөвгүй ТАХ-г дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад баталж Төсвийн тухай хуулийн 29.4¹³ дэх заалтыг зөрчиж 20,306.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 60 ТАХ-ний ХАА-г түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэйгөөр зохион байгуулжээ.

Шаардлагад нийцсэн тендер ирүүлээгүй оролцогчдоос гомдол гаргасан шалтгаанаар 12 ТАХ-ний ХАА хугацаа хойшлогджээ. Тухайлбал:

- БГД-т хэрэгжих “Нийтийн эзэмшлийн орон сууцны цахилгаан шат солих шинэчлэлтийн ажил, 25-р хороо”, төсөвт өртөг 120.0 сая төгрөг;
- СХД-т хэрэгжих “Эрүүл мэндийн төвд автомашин худалдан авах”, төсөвт өртөг 70.0 сая;
- ЧД-т хэрэгжих “4-р хороо 9-р цэцэрлэг дээвэр, цахилгаан, сантехник засвар”, төсөвт өртөг 257.8 сая төгрөг;
- ХУД-т хэрэгжих “Эко ахмадын сувилал” ОНӨААТҮГ-т шаардлагатай тавилга, тоног төхөөрөмж, хэрэгсэл худалдан авах /8-р хороо/, төсөвт өртөг 314.0 сая төгрөг.

Дээрх байдлаар хугацаа алдсанаас 2021 онд зохион байгуулахаар батлагдсан 275 ТАХ-ээс 35 ТАХ буюу 12.7% нь он дамжин хэрэгжжээ.

Дүгнэлт: Төсөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нь ХАА-ны үр дүнд нөлөөлж байна.

Б.1.3. Худалдан авах ажиллагааг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор ханган, зохион байгуулж, шаардлага хангасан гүйцэтгэгч шалгаруулсан уу?

Дүүргийн ЗД нарын 46 удаагийн захирамжаар ХАА-г зохион байгуулан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороодыг байгуулжээ.

ХАА зохион байгуулсан ТАХ-ний худалдан авалтын 49.4%-ийг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар, 11.4%-ийг зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмаар, 35.5%-ийг харьцуулалтын аргаар, 3.6%-ийг шууд гэрээ байгуулах аргаар тус тус зохион байгуулжээ.

Хүснэгт 12. Худалдан авах ажиллагаа зохион байгуулсан журам

№	Дүүргийн нэр	/сая.төг/									
		Гүйцэтгэгч сонгон шалгарсан		Нээлттэй тендер шалгаруулалт		Харьцуулалтын арга		Шууд гэрээ байгуулах		Зөвлөх үйлчилгээ	
		Тоо	Гэрээний үнэ	Тоо	Гэрээний үнэ	Тоо	Гэрээний үнэ	Тоо	Гэрээний үнэ	Тоо	Гэрээний үнэ
1	БЗД	9	1,092.70	1	226.1	6	271.6	-	-	2	595
2	БГД	19	3,853.50	14	3,676.00	5	177.5	-	-	-	-
3	СХД	16	3,023.70	5	2,473.50	9	525.8	2	24.4	-	-
4	СБД	48	4,096.20	33	3,466.50	9	401.4	-	-	6	228.3

¹¹ 9.4.Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

¹² 48.3.Төсвийн ерөнхийлөн захирагч улсын төсөв батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор энэ хуулийн 45.4-т заасан худалдан авах бараа, ажил, үйлчилгээний захиалгыг төсөл, арга хэмжээ бүрийн техникийн тодорхойлолт, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, ажлын даалгавар болон бусад шаардлагатай мэдээллийн хамт худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагад хүргүүлнэ.

¹³ 29.4 Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

5	ХУД	33	20,638.30	19	17,194.40	7	446.5	4	2,725.80	3	271.6
6	ЧД	35	3,885.10	9	2,498.60	18	1,044.90	-	-	8	341.6
7	БНД	5	240.3	-	-	4	195.5	-	-	1	44.8
8	БЖД	2	134.9	1	125	1	9.9	-	-	-	-
	Нийт	167	36,964.70	82	29,660.10	59	3,073.10	6	2,750.20	20	1481.3

ТБОНӨХБАҮХАТХ-ийн 47 дугаар зүйлийн 47.4¹⁴-т заасны дагуу үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл буюу дүүргийн ЗДТГ-ын салбарын мэргэжилтнүүд, “ИТХ-аас томилсон 17 иргэнийг оролцуулсан байна.

ХАА-ны ил тод байдлыг хангах хүрээнд ТБОНӨХБАҮХАТХ-ийн 21 дүгээр зүйлийн 21.2¹⁵-т заасны дагуу гэрээ хийгдсэн 36,964.7 төгрөгийн төсөвт өртөгтэй 167 ТАХ-г Төрийн Худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системээр зохион байгуулжээ.

БГД-ийн ХААА нь 3,853.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 19 ТАХ-ний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа тендерийн баримт бичгийг баталсан байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 45 дугаар зүйлийн 45.3¹⁶, Сангийн сайдын 2014 оны 212 дугаар тушаалын 3.2¹⁷ дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Аудитад 2021 онд ХАА зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан 40,088.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 167 ТАХ-г 100.0% хамруулан шалгахад дараах зөрчлүүд илэрсэн. *Хавсралт 5, 6.* Тухайлбал:

БГД-ийн ХАА-ны албанаас зохион байгуулсан ТАХ:

- “Орчны тохижилт (21 дүгээр хороо 278 дугаар цэцэрлэг орчим)” ажил. Төсөвт өртөг 165.5 сая төгрөг. Гүйцэтгэгч “Веллко-Инк” ХХК. ТББ-т тусгасан баримт материалыг ирүүлээгүй байна. Үүнд: Ажлын талбайн зохион байгуулалтын зураг, тайлан, ажлын талбайтай танилцсан тэмдэглэл, зураг төслийг боловсруулан, магадлагаар баталгаажуулан, барилга угсралтын ажлыг гүйцэтгэж ашиглалтад хүлээлгэн өгөх баталгааг бичгээр гаргаж ирүүлээгүй.
- “Нийтийн зориулалттай орон сууцны орчны засвар /1, 3, 10 дугаар хороо/” ажил. Төсөвт өртөг 53.8 сая.төгрөг. Гүйцэтгэгч “Ээбо пропертийз” ХХК. 1.ТОӨЗ 22.6 Улсын бүртгэлийн гэрчилгээ болон тусгай зөвшөөрлийн хуулбарыг нотариатаар баталгаажуулаагүй. Ажлын талбайн зохион байгуулалтын зураг, тайланг ирүүлээгүй. 2021.10.30-ний өдийн тодорхойлолтоор 476,700 төгрөгийн өртөй, 9 дүгээр сарын нийгмийн НД-8 маягтыг ирүүлээгүй байна. Зураг төсөв боловсруулах гэрээнд хийгдэх ажил, үнийн дүнг тусгаагүй.

БНД-ийн ХАА-ны албанаас зохион байгуулсан ТАХ:

- “Нийтийн эзэмшлийн явган замын хавтан, эко хавтан, блок үйлдвэрлэх тоног төхөөрөмж худалдан авах” ажил. Төсөвт өртөг 79.4 сая төгрөг. Гүйцэтгэгч “Хэрлэнгийн боргио” ХХК. ТББ-ын 5, 6-р бүлэгт заасан гэрээний Ерөнхий болон Тусгай нөхцөл, маягт зэргийг зөвшөөрч байгаа талаарх мэдэгдлийг ирүүлээгүй.
- “Дүүргийн авто замын засвар шинэчлэлтийн зураг төсөв боловсруулах” ажил Төсөвт өртөг 44.8 сая.төгрөг. Гүйцэтгэгч “Брос Проперти” ХХК. Зөвлөх хуулийн этгээдийн /2018, 2019/ аудитаар баталгаажуулаагүй тайлан ирүүлсэн. Нийгмийн даатгалын дэвтрийн албан тушаалын өөрчлөлтийн тэмдэглэл, сүүлийн 3 жилийн нийгмийн даатгал төлсөн хэсгийн хуулбарыг ирүүлээгүй.

¹⁴ 47.4.Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, орон нутаг тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна.

¹⁵ 21.2.Захиалагч тендер шалгаруулалтын тухай дэлгэрэнгүй мэдээллийг ил тод, нээлттэй зарлах бөгөөд сонирхсон этгээдэд саадгүй олгоно.

¹⁶ 45.3.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээний хувьд тухайн шатны Засаг даргын Тамгын газар захиалагч байна.

¹⁷ 3.2 Үнэлгээний хороо тендерийн баримт бичгийн төслийг боловсруулан захиалагчаар батлуулж, баталгаажсан хувийг тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээдэд тараана.

СБД-ийн ХАА-ны албанаас зохион байгуулсан ТАХ:

- “14 дүгээр хороо, Өнөр өрх өрхийн эрүүл мэндийн төв, дүүргийн Ахмадын хорооны цогцолбор байрны засварын ажил”. Төсөвт өртөг 61.9 сая төгрөг. Гүйцэтгэгч “Хийц Тауэр” ХХК. НД-ын өргүй тухай тодорхойлолт ирүүлээгүй. Шалгарсан компанийн Ерөнхий инженер, ХАБЭА ажлыг 1 хүнээр хийлгэхээр томилсон. Шалгарсан компанийн түргэн хөрвөх хөрөнгийг тодорхойлох банкны тодорхойлолт шаардлага хангаагүй.
- “6-р хороо, 47-р байрны гадна фасад засвар” ажил. Төсөвт өртөг 96.5 сая төгрөг Гүйцэтгэгч Тэнгэрийн модон багана ХХК. Ажлын талбайн зохион байгуулалтын зураг болон ажлын талбайтай танилцсан тэмдэглэл ирүүлээгүй. Шаардагдсан жилийн НД-7, НД-8 дугаар маягтыг дутуу ирүүлсэн. Мэргэжилтэй ажилчдын үнэмлэхийн хуулбар болон иргэний үнэмлэхийн хуулбарыг ирүүлээгүй. Тээврийн хэрэгслийн гэрчилгээ, фото зургийг ирүүлээгүй. ТББ-ийн 5, 6 дугаар бүлэгт заасан гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг зөвшөөрч байгаа эсэх талаар мэдэгдэл ирүүлээгүй.

СХД-ийн ХАА-ны албанаас зохион байгуулсан ТАХ:

- “Эрүүл мэндийн төвд автомашин худалдан авах” ажил. Төсөвт өртөг 61 сая төгрөг. Гүйцэтгэгч Дипирамид ХХК. Сүүлийн 3 жилийн борлуулалтыг орлого ирүүлээгүй. Ижил төстэй ажил хийж байсан туршлагыг нотлох материал ирүүлээгүй. ТББ-т заасан 4.2.1 - 4.2.9-д дурдсан нөхцөл үүссэн эсэх тухай мэдэгдэл болон 5, 6-р бүлэгт заасан гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, маягт зэргийг зөвшөөрч байгаа талаар мэдэгдэл ирүүлээгүй. Нийлүүлэх барааны зураг болон танилцуулга ирүүлээгүй.
- “Гүний худаг барих /21 дүгээр хороо/” ажил. Төсөвт өртөг 47.7 сая төгрөг. Гүйцэтгэгч Грандхолдинг ХХК. Тендерийн урилгыг олон нийтэд зарлан мэдээлээгүй. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн тодорхойлолт ирүүлээгүй. Сүүлийн 3 жилийн борлуулалтыг орлого ирүүлээгүй.

ХУД-ийн ХАА-ны албанаас зохион байгуулсан ТАХ:

- “Гүний худаг байгуулах /9, 11, 12, 13, 14-р хороо/” ажил. Төсөвт өртөг 233.2 сая төгрөг. Гүйцэтгэгч Топ-дриллинг ХХК. Топ-дриллинг ХХК-д холбогдох ажил, ажил гүйцэтгэх үүрэгт 18.9 сая төгрөг гаргуулах тухай иргэний хэрэгт хариуцагчаар оролцож байсан шүүхийн тодорхойлолт ирүүлсэн нь шаардлага хангаагүй. Усны барилга байгууламжийн инженерээр ажиллах хүний албан тушаал жолооч, нярав байгаа нь шаардлагад нийцээгүй.
- “Цагдаагийн 1, 2 дугаар хэлтсийн байрны фасад, дээвэр засвар /6, 20-р хороо/” ажил. Төсөвт өртөг 217.7 сая төгрөг. Гүйцэтгэгч Улаан элс ХХК. Шалгарсан компанийн ХАБЭА ажилтны мэргэжлээрээ ажилласан байх жил нь ТББ-т заасан шалгуурыг хангаагүй. Бусад инженер, техникийн ажилтнуудын ажилласан жил нотлогдоогүй.

ЧД-ийн ХАА-ны албанаас зохион байгуулсан ажил:

- “7, 8, 18 дугаар хороодын хөрсний ус зайлуулах, шүүрүүлэх байгууламжийн зураг төсөв” ажил. Төсөвт өртөг 27.1 сая төгрөг. Гүйцэтгэгч Силвер Эделвэйз ХХК. Ажлын талбайн зохион байгуулалтын зураг, тайлан болон ажлын талбайтай танилцсан тэмдэглэл ирүүлээгүй. Ижил төстэй ажлын хүлээлгэж өгсөн улсын комиссын акт, захиалагчийн тодорхойлолтыг ирүүлээгүй. ТББ-т заасан 4.2.1 - 4.2.9-д дурдсан нөхцөл үүссэн эсэх тухай мэдэгдэл, гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, маягт зэргийг зөвшөөрч байгаа талаарх мэдэгдэл зэргийг ирүүлээгүй. Гэрээний үнэ, хугацаанд багтаан ажлын даалгаврын нөхцөлийн дагуу чанарын өндөр түвшинд зураг төслийг боловсруулан, магадлалаар оруулж баталгаажуулан, барилга угсралтын ажлыг гүйцэтгэж ашиглалтад хүлээлгэн өгөх тухай баталгааг бичгээр гаргаж ирүүлээгүй.
- “17 дугаар хороо авто замын зураг төсөв” ажил Төсөвт өртөг 64.9 сая төгрөг. Гүйцэтгэгч Классикроуд ХХК. ТББ-т тусгасан баримт материалыг ирүүлээгүй байна. Үүнд: Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурах этгээдийн итгэмжлэл, холбогдох асуудлаар тодорхойлолт авахад татгалзах зүйлгүй тухай, 4. 2. 1 - 4. 2. 9-д дурдсан

нөхцөл үүссэн эсэх тухай, гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, маягт зэргийг зөвшөөрч байгаа тухай, тендерийн үнийн дүнг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай мэдэгдлүүд болон, нийгмийн даатгалын тодорхойлолт, харилцагч банкны тодорхойлолт зэргийг ирүүлээгүй.

Аудитад хамрагдсан 167 ТАХ-ний тендерийн баримт бичиг, гүйцэтгэгчээс ирүүлсэн баримт, материалыг шалгуур үзүүлэлттэй тулган шалгахад 15,921,2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий дээрх 59 ТАХ-нд шаардлага хангаагүй гүйцэтгэгчийг шалгаруулсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.3 “Тендер нь энэ хуулийн 27.1-д заасан бүх нөхцөлийг нэгэн зэрэг хангасан бол шаардлагад нийцсэн тендер гэж үзнэ” гэсэн заалтыг зөрчжээ.

Хүснэгт 13. Тендерийн баримт бичигт заасан нөхцөл хангаагүй гүйцэтгэгч шалгаруулсан

№	ХАА зохион байгуулсан	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Шалгуур хангаагүй үзүүлэлтийн тоо	/сая.төг/
1	БГД-ийн ХААА	9	1,182.5	20	
2	БНД-ХААА	2	124.2	3	
3	СБД-ХААА	16	2,267.0	29	
4	СХД-ХААА	3	153.3	10	
5	ХУД-ХААА	10	10,594.4	14	
6	ЧД-ХААА	19	1,599.8	51	
	Нийт	59	15,921.2	127	

Дээрх 59 гүйцэтгэгчийн ирүүлсэн материалыг шалгахад ерөнхий нөхцөлийг магадлах шалгуур 95, техникийн чадавх болон туршлагыг үнэлэх шалгуур 31, нийт 127 шалгуур үзүүлэлтийг хангаагүй байна.

Цаашид илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй байх, тендерт оролцогчдоос ирүүлсэн баримт материалыг үнэн зөвөөр үнэлэх, шаардлага хангаагүй гүйцэтгэгч сонгон шалгаруулдаг зөрчлийг таслан зогсоож, үнэлгээний хорооны гишүүдийн үүрэг, хариуцлагыг дээшлүүлж, хууль тогтоомжийг мөрдлөг болгон ажиллах, зөрчил гаргасан албан тушаалтнуудад хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Дүгнэлт: ХАА-г зохион байгуулахдаа ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор хангасан байна. Гүйцэтгэгч сонгон шалгарсан 38,264.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй 167 ТАХ-ээс 15,921.2 сая төгрөгийн дүнтэй 59 ТАХ буюу 35.3 %-нь ТББ болон ТБОНӨХБАҮХАТХ-ийн 14-16 дугаар зүйлийн шаардлагыг хангаагүй байна.

Б.1.4. Худалдан авах ажиллагааны тайланг үнэн зөв гаргаж, хугацаанд нь тайлагнасан уу?

2021 онд зохион байгуулсан ХАА-ны тайланг ТБОНӨХБАҮХАТХ-ийн 49.5, Сангийн сайдын “Журам шинэчлэн батлах тухай” 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 102 дугаар тушаалаар “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-д заасны дагуу нэгтгэж бүтэн жилийн тайланг дараа оны 01.15-ны өдрийн дотор төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ гэж заажээ.

Дүүргүүд цахим болон цаасан хэлбэрээр хагас жилийн тайланг 2021 оны 07 дугаар сарын 15, бүтэн жилийн тайланг 2022 оны 01 дүгээр сарын 15-ний дотор хугацаанд нь НХААГ болон Сангийн яаманд хүргүүлжээ.

ХУД, БГД-үүд тоон мэдээг дутуу болон зөрүүтэй илэрхийлсэн байна. Үүнд:

- ХУД-ХААА гүйцэтгэгч сонгон шалгарсан 480.0 сая төгрөгийн өртөгтэй “Орчны тохижилт” ТАХ-г ХАА-ны жилийн эцсийн мэдээ тайланд тусгаагүй;
- БГД-ХААА нь 870.0 сая төгрөгийн өртөгтэй 3 ТАХ-ний батлагдсан төсөвт өртгийг 30-300 сая төгрөгийн зөрүүтэй тайлагнасан. Үүнд:
 - Орчны тохижилт /9 дүгээр хороо, 146 дугаар сургууль орчим/, төсөвт өртөг 170.0 сая төгрөг;
 - Орчны тохижилт /21 дүгээр хороо, 278 дугаар цэцэрлэг орчим/, төсөвт өртөг 500.0 сая төгрөг;
 - Тохижилт бүтээн байгуулалтын ажил, төсөвт өртөг 200.0 сая төгрөг.

Дүгнэлт: ТАХ-ний ХАА-ны тайланг хугацаанд нь цахим болон цаасан хэлбэрээр тайлагнасан ч зарим тоон мэдээг зөрүүтэй, дутуу илэрхийлсэн байна.

Б.2 Захиалагч гэрээний хэрэгжилтийг хугацаанд нь бүрэн хангуулж, хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн үү?

Дүүргүүдэд өмнөх оноос дамжин хийгдсэн болон 2021 онд шинээр эхэлсэн 78,558.7 сая төгрөгийн гэрээний дүнтэй 250 ТАХ-нд дүүргүүдийн ЗДТГ болон “НХОГ” ОНӨААТҮГ, НАЗХГ, “Хүн төвтэй хот төлөвлөлтийн лаборатори” НҮТББ, СХД-ын Захиалагчийн алба зэрэг газрууд гэрээгээр захиалагчийн хяналт хэрэгжүүлжээ.

Б.2.1. Гүйцэтгэгч хөрөнгө оруулалтын ТАХ-г зураг төсөв, техникийн тодорхойлолтын дагуу гэрээний хугацаанд үр дүнтэй гүйцэтгэсэн үү?

Дүүргүүдийн хэмжээнд 2021 онд 23,858.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй 168 ТАХ хэрэгжиж дууссан, 10,865.67 төгрөгийн дүнтэй 27 ТАХ 50-95%-ийн гүйцэтгэлтэй, 29,619.3 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 10 ТАХ 20-50%-ийн гүйцэтгэлтэй байна. Харин 14,215.7 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 45 ТАХ тухайн онд хэрэгжиж эхлээгүй байна.

Хэрэгжиж эхлээгүй болон хэрэгжилт дутуу ТАХ-ны шалтгааныг тодруулахад дараах байдалтай байна. Тухайлбал:

- БГД-т “Түрээсийн орон сууцны барилгын ажил”, гэрээний дүн 5,268.2 сая төгрөг. Гүйцэтгэгч Хөх хайрхан трейд ХХК. 2020.07.08-нд эхэлсэн. 2021 онд 1,900.0 төгрөгийн санхүүжилт олгогдсон. Үлдэгдэл санхүүжилт батлагдаагүйгээс барилгын ажил 37% -тай 2022 оны төсөвт санхүүжилт тусгагдаагүй.
- БЗД-т “Баянзүрх дүүргийн 1, 5, 6, 7, 9, 13, 15, 17, 20, 25 дугаар хороодод явган зам, талбайн шинэчлэлийн ажил”, гэрээний дүн 226.1 сая төгрөг. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар зарим хороодын ажил хийгдсэн, ажлын давхцал үүссэн учир хийгдсэн ажлын хүрээнд санхүүжилт олгосон.
- СБД-т “7 дугаар хорооны ӨЭМТ, цагдаа, хорооны ажлын албаны нэг цэгийн үйлчилгээний байр шинээр барих”, 592.7 сая төгрөгийн гэрээний дүнтэй. 2015 оны ажил, газрын маргаантай учир баригдаж эхлээгүй шүүхийн маргаантай.
- СХД-т “Хот тохижилтын тусгай зориулалтын техник хэрэгсэл, машин механизм”, гэрээний үнийн дүн 240.5 сая төгрөг. Шүүхийн маргаантай тул хэрэгжиж эхлээгүй.
- ХУД-т “6, 7 дугаар хорооны голын засмал замын гадаргын ус зайлуулах шугам татах ажлын үлдэгдэл санхүүжилт”, гэрээний дүн 50.9 сая төгрөг. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ТАХ-тэй давхацсан тул гэрээ цуцалсан.
- ЧД-т “Иргэд хүүхэд залуучуудад, ахмад настанд зориулсан хөгжлийн төв, спорт заал барих”, гэрээний үнийн дүн 1,496.7 сая төгрөг. Ажил эхлэх хугацаа 2018 он. Ажлын гүйцэтгэл 38% тай байхад 63%-н санхүүжилт олгосон. Гүйцэтгэгч “Баян-Могод” ХХК нь ажлыг дутуу хийсэн, захиалагчаас тус гүйцэтгэгчийг хуулийн байгууллагад шилжүүлсэн.

Аудитад 2021 онд хэрэгжиж дууссан 23,858.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 168 ТАХ-ны төрөл бүрээс түүвэрлэн 20,078.8 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 145 ТАХ-г хамруулан газар дээр нь шалгаж тулган баталгаажуулалт хийхэд дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

БГД-ын “Хүн төвтэй хот төлөвлөлтийн лаборатори”, дүүргийн тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсээс хяналт тавьсан 2,491.2 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 17 ТАХ-г 100% хамруулан шалгахад 2 ТАХ-нд зөрчил илэрсэн.

- “Баянгол шинэ өргөө” ОНӨААТҮГ-ын хог тээврийн авто машин худалдан авах. Гэрээний үнийн дүн 749.0 сая төгрөг. Гүйцэтгэгч: Хьондай Моторс Монгол ХХК. 2021.08.20 өдөр 2 сарын хугацаанд хог тээврийн 3 автомашин нийлүүлэх гэрээ байгуулсан ч 1 машиныг нийлүүлээгүй. Гэрээг 2022.02.18 хүртэл дахин сунгасан. Гэвч дээрх компани нь гэрээний хугацаа дуусаж байхад буюу 2021.11.10-ны өдөр үйлдвэрлэгч рүү төлбөрөө шилжүүлж машиныг захиалгад оруулж 2022 оны 1 сард Монгол Улс руу ачуулсан.
- “Баянгол цагдаагийн нэгдүгээр хэлтэс”. Гэрээний үнийн дүн 170.0 сая төгрөг. Гүйцэтгэгч: Хөх гүрэн ХХК. 2021.06.03-ны өдөр 2 сарын хугацаатай гэрээ байгуулсан. Хил гаальтай холбоотойгоор бараа материал ирээгүй шалтгаанаар ажлыг бүрэн дуусгаагүй. Сүүлийн гэрээ дүгнэсэн протокол 80%. Гэвч засварын ажлыг хангалтгүй хийсэн. Ашиглагч байгууллагаас удаа дараа гомдол гаргасан.

БНД-ын тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн хяналт тавьсан 317.0 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 13 ТАХ-г бүрэн хамруулахад 1 ТАХ-нд зөрчил илэрсэн.


- “Соёлын ордонд дуу бичлэгийн студи байгуулахад шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах”. Гэрээний дүн: 19.4 сая төгрөг. Гүйцэтгэгч: Крейссэн ХХК. Гэрээний хэрэгжилт 100% гэж үзэн 95%-н санхүүжилтийг олгосон. Суурилуулалтын ажлын хөлс 500,000 төгрөг ажлын тоо хэмжээнд тусгагдсан. Гэвч суурилуулалт хийгдээгүй, суурин компьютерын процессор хуучирч элэгдсэн, лац нь хөдөлсөн, холбогч утасны тоо хэмжээ дутсан.

СБД-ын тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн хяналт тавьсан 4,239.4 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 42 ТАХ-г түүвэрлэн үзэхэд 4 ТАХ-нд зөрчил илэрсэн.

- “143 дугаар цэцэрлэгийн өргөтгөлд шаардлагатай тавилга тоног төхөөрөмж худалдан авах” Багц 7. Гэрээний дүн: 40.3 сая төгрөг. Гүйцэтгэгч: Хаан Кастл ХХК. Тавилга, эд хогшил нийлүүлэхдээ зах зээлийн үнээс 1.3-1.5 дахин өндөр үнэлгээтэйгээр нийлүүлэгдсэн байхад захиалагчийн хяналт хэрэгжүүлэхдээ харьцуулсан бодит үнийн тооцоог хийгээгүй.

Зураг 1. Хөргөгчийг худалдан авсан үнэ 9.9 сая төгрөг, зах зээлийн үнэ 7.7 сая төгрөг.

Зураг 2. Агаар цэвэршүүлэгч худалдан авсан үнэ 1.1 сая төгрөг, зах зээлийн үнэ 0.5 сая төгрөг.



- “12 дугаар хорооны цэцэрлэгийн бараа” Багц 1. Гэрээний дүн: 12.7 сая төгрөг. Гүйцэтгэгч: Хаан Кастл ХХК, Багц 7. Гэрээний дүн 58.0 сая төгрөг. Гүйцэтгэгч Дөчисон

Трейд ХХК. Тавилга эд хогшил нийлүүлэхдээ зах зээлийн үнээс 1.5-2 дахин өндөр үнэлгээтэйгээр нийлүүлэгдсэн байхад захиалагчийн хяналт хэрэгжүүлэхдээ харьцуулсан бодит үнийн тооцоог хийгээгүй.

Зураг 3. Ногоо хэрчигч худалдан авсан үнэ 3.3 сая төгрөг, зах зээлийн үнэ 2.6 сая төгрөг.



Зураг 4. Принтер авсан үнэ 3.0 сая төгрөг, зах зээлийн үнэ 1.8 сая төгрөг.

Зураг 5. Хөргөгчийг худалдан авсан үнэ 9.9 сая төгрөг, зах зээлийн үнэ 7.7 сая төгрөг.



- “Төрийн үйлчилгээний барилга байгууламжийн зураг төсөв боловсруулах”, Гэрээний дүн 49.9 сая төгрөг. Боловсролын салбарын барилгын ажлын зураг төсөв боловсруулах”. Гэрээний дүн: 49.9 сая төгрөг. Гүйцэтгэгч: Зэндмэнэ тулга ХХК. 2021.01.21-2021.03.21 -ний хооронд зургийг ажлын хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулсан ч дээрх 2 ажлын гэрээг тус бүр 6 сараар шалтгаангүйгээр сунгасан.

СХД-ын Захиалагчийн алба ОНӨААТҮГ-аас захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн ТАХ. Нийт 544.9 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 6 ТАХ-г түүвэрлэн үзэхэд 1 ТАХ-нд зөрчил илэрсэн.

- “Амралт цогцолборын газрын барилга 21-р хороо”. Гэрээний дүн 248.0 сая төгрөг. Гүйцэтгэгч “Алтайн Шар Говь” ХХК. Барилгын бүтээцэд өөрчлөлт орж хана хэд хэдэн байршилд ноцтой цуурсан байхад захиалагчаас Барилгын тухай хуулийн 46.1.11¹⁸ дэх заалтын дагуу холбогдох арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлээгүй, “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 3.6¹⁹ дэх заалтыг зөрчсөн.

ЧД-ын тохижилт, нийтийн аж ахуйн захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн ТАХ. Нийт 3,991.1 сая төгрөгийн гэрээний дүнтэй 36 ТАХ-г 100% хамруулахад 2 ТАХ-нд зөрчил илэрлээ.


- “13-р хороо 56-р цэцэрлэг хэсэгчилсэн засвар”. Шууд гэрээний үнийн дүн: 14,3 сая төгрөг. Гүйцэтгэгч: Нью Баян баяр терма ХХК. Гэрээт ажлыг гүйцэтгэх эхлээгүй байхад 95%-ийн санхүүжилт олгосон.
- “16-р хороо 139-р сургууль биеийн тамирын талбайн тохижилт”. Шууд гэрээний үнийн дүн: 18.0 сая төгрөг. Ажлын тоо хэмжээнд тусгагдсан талбайн хиймэл зүлгийн ажил хийгдээгүй байхад санхүүжилтийг 95% олгосон. Аудитын явцад талбайн хиймэл зүлгийн ажлыг бүрэн хийлгэж зөрчлийг арилгуулсан.

¹⁸ Барилгын хийц, бүтээцэд ан цав, цууралт үүсэх зэрэг ноцтой эвдрэл, гэмтэл гарсан тохиолдолд барилгын улсын хяналтын асуудал эрхэлсэн байгууллагад хандаж дүгнэлт гаргуулан, холбогдох арга хэмжээг авах;

¹⁹ Захиалагч зураг төсөл зохиогч болон гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг тогтоосон хугацаанд дүгнэж, зураг төсөл зохиогч, гүйцэтгэгч гэрээний дагуу хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, эсхүл зөрчил, дутагдал илэрсэн тохиолдолд гэрээ болон хууль тогтоомжид заасан хариуцлагыг тооцож ажиллана.

- “Чингэлтэй дүүргийн Прокурорын газарт суудлын автомашин”. Гэрээний дүн 39.9 сая төгрөг. Гүйцэтгэгч: Модерн хас ХХК. Прокурорын газрын албан хэрэгцээнд суудлын автомашин нийлүүлэхдээ зах зээлийн үнээс 1.3-1.4 дахин өндөр үнэлгээтэйгээр нийлүүлэгдсэн байхад захиалагчийн хяналт хэрэгжүүлэхдээ харьцуулсан бодит үнийн тооцоог хийгээгүй.

Зураг 6. Приус 41 автомашин худалдан авсан үнэ 39.9 сая төгрөг, зах зээлийн үнэ 30.0 сая төгрөг.



НАЗХГ-аас захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн ТАХ. Нийт 694.0 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 4 ТАХ-г шалгахад 1 ТАХ-нд зөрчил илэрсэн.

“СБД-ийн12-р хороо зам засварын ажил”, гэрээний үнийн дүн: 190.6 сая төгрөг. Гүйцэтгэгч: Бумбат даваа ХХК. ажлын даалгаварт 1.8м явган замын чиглүүлэгч хавтанг тусгаж өгөөгүй байхад хяналт хэрэгжүүлсэн. Талбайн журнал болон холбогдох баримт материалууд байхгүй, захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн нь тодорхойгүй.

Иймд илэрсэн зөрчлүүдийг шуурхай арилгаж, давтан гаргахгүй байх, холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцох талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд хугацаатай албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Дүгнэлт: Аудитын түүвэрт хамрагдсан 20,078.8 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 145 ТАХ-ээс 2,203.1 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 13 ТАХ буюу 9.0%-д нь захиалагчийн хяналтыг хангалтгүй, үр дүн муутай хэрэгжүүлсэн байна. Өнгөрсөн онтой харьцуулахад зөрчил багассан ч дахин давтагдаж байгаа нь төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнд нөлөөлж байна.

Б.2.2. Эрх бүхий этгээд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн үү?

Захиалагчийн хяналтыг дүүргүүдийн ЗДТГ-ын тохижилт, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтнүүд болон “НХОГ” ОНӨААТҮГ, НАЗХГ, СХД-ийн Захиалагчийн алба ОНӨААТҮГ, “Хүн төвтэй хот төлөвлөлтийн лаборатори” НҮТББ зэрэг газрууд хэрэгжүүлжээ.

ЗГ-ын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан “Барилга захиалагчийн дүрэм”-ийн 2.2²⁰, 2.5²¹-д заасны дагуу шаардлага хангасан эрх бүхий этгээдүүд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлдэг.

Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн дээрх этгээдүүд эрх бүхий эсэхийг дүрэм, чиг үүрэг, албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт, гүйцэтгэлийн төлөвлөгөө, холбогдох баримт бичиг зэрэгтэй тулган шалгасан. Үүнд:

²⁰ 2.2.Барилга байгууламжийн хөрөнгө оруулагч захиалагчийн чиг үүрэг хэрэгжүүлэх этгээдийг байнгын ажиллагаатай, эсхүл тухайн барилга байгууламжийн барилгын ажил гүйцэтгэх хугацаагаар байгуулан ажиллуулах бөгөөд Барилгын тухай хуулийн 37.2-т заасан мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх этгээдээр захиалагчийн чиг үүргийг төлөөлүүлэн хэрэгжүүлж болно.

²¹ Захиалагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх хуулийн этгээд нь мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан, дадлага, туршлага, бүхий бүрэлдэхүүн байна.

- Дүүргүүдэд хэрэгжиж байгаа зарим ТАХ, үүний дотор авто зам, барилга, байгууламжийн хяналтыг мэргэжлийн чиг үүрэг бүхий НАЗХГ /дүрмийн 3.2²²/, “НХОГ” ОНӨААТҮГ /дүрмийн 4.3.1²³/, хэрэгжүүлж байна. Харин дийлэнх ТАХ-г дүүргүүдийн ЗДТГ-ын харьяа хэлтсүүдийн мэргэжилтнүүд хэрэгжүүлжээ.
- БГД-т 870.2 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 8 ТАХ-ний захиалагчийн хяналтыг “Хүн төвтэй хот төлөвлөлтийн лаборатори” НҮТББ ЗДТГ-тай гэрээ байгуулан хэрэгжүүлсэн. ЗГ-ын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан “Барилга захиалагчийн дүрэм”-ийн 2.2²⁴-т заасан мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх бүхий этгээдүүд байна гэж заасан. Гэтэл “Хүн төвтэй хот төлөвлөлтийн лаборатори” НҮТББ нь мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх бүхий, захиалагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх хуулийн этгээд нь мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан, дадлага, туршлага, бүхий бүрэлдэхүүн байх гэдгийг хангасан талаарх нотлох баримт ирүүлээгүй;
- ХУД, ЧД, БГД, СБД, БНД-үүдэд тохижилт, ногоон байгууламж, засвар үйлчилгээ, явган замын ажлуудад дүүргүүдийн тохижилт, төлөвлөлтийн хэлтсүүдийн мэргэжилтнүүд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн;

Дүгнэлт: Зарим дүүрэгт Барилга захиалагчийн дүрэмд заасан шаардлага хангаагүй этгээдүүд захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн байна.

Б.2.3. ТАХ-ний хэрэгжилтэд тавих захиалагчийн болон зохиогчийн үе шатны хяналтыг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлсэн үү?

ЗГ-ын 2017 оны 170 дугаар тушаалаар батлагдсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”ийн 3.9²⁵-д заасны дагуу захиалагч нь үе шатны ажилд хяналт хэрэгжүүлэхдээ холбогдох ил далд ажлын акт, холбогдох баримт материалыг, графикт хугацаа, гэрээний дагуу хянаж баталгаажуулсан эсэхийг шалгасан.

Захиалагчаас ажлын гүйцэтгэлийг баталгаажуулахдаа ил далд ажлын актууд, үе шатны ажлын гүйцэтгэлийн тэмдэглэлүүд, холбогдох бусад баримт бичгийг үндэслэж байна. ТАХ-ний хүрээнд давхардсан тоогоор туршилт тохируулга хийсэн болон ил далд ажлын 182 төрлийн 220 актыг холбогдох албан тушаалтнууд /захиалагч, зохиогч, гүйцэтгэгчийн төлөөлөл, инженерүүд/ баталгаажуулжээ.

Хүснэгт 14. Гүйцэтгэлийн шатанд баталгаажуулсан актууд

Туршилт тохируулга хийсэн акт		Далд ажлын актууд		Ил ажлын актууд	
Төрөл	Тоо	Төрөл	Тоо	Төрөл	Тоо
37	49	48	67	97	104

Дээрх байдлаар ажил гүйцэтгэх явцад үе шатны ажлын технологийн дарааллын дагуу холбогдох баримт бичиг, барилгын ажил гүйцэтгэх төлөвлөгөө, график, санхүүжилт зэргийг тухай бүр хянан баталгаажуулдаг байна.

²² 3.2. нийслэлийн авто замын салбарт хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хүрээнд авто зам, замын байгууламжийг шинээр барих, өргөтгөн шинэчлэх, урсгал засвар, ашиглалт, арчлан хамгаалалтын ажлыг зохион байгуулж, захиалагчийн болон лабораторийн хяналт тавих, ашиглалтад хүлээлгэн өгөх;

²³ 4.3.1-т үйлдвэрийн газрын үйл ажиллагааны үндсэн чиглэл нь улс, нийслэлийн төсөв, гадаадын хөрөнгө оруулалт, зээл тусламжийн хөрөнгөөр барилга байгууламж шинээр барих, өргөтгөх, шинэчлэн засварлах үйл ажиллагаанд гэрээний үндсэн дээр хяналт тавих

²⁴ 2.2.Барилга байгууламжийн хөрөнгө оруулагч захиалагчийн чиг үүрэг хэрэгжүүлэх этгээдийг байнгын ажиллагаатай, эсхүл тухайн барилга байгууламжийн барилгын ажил гүйцэтгэх хугацаагаар байгуулан ажиллуулах бөгөөд Барилгын тухай хуулийн 37.2-т заасан мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх этгээдээр захиалагчийн чиг үүргийг төлөөлүүлэн хэрэгжүүлж болно.

²⁵ 3.9.Захиалагч үе шатны ажилд техникийн хяналт тавих, гүйцэтгэлийн тэмдэглэл, ил далд ажлын болон тоног төхөөрөмжийн угсралт, туршилт, тохируулга хийсэн акт, санхүүжилтийн тооцоо, холбогдох бусад баримт бичгийг барилгын ажил гүйцэтгэх график, гэрээний дагуу барилгын үйл ажиллагаанд оролцогчтой хамтран хянаж, баталгаажуулахаас гадна техникийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий этгээдтэй хамтарсан үзлэг шалгалтыг урьдчилан сэргийлэх зорилгоор тухай бүр хийсэн байна.

Дүгнэлт: Барилга байгууламж, авто зам, засварын үе шатны ажлын ил далд актууд болон туршлага тохируулга хийсэн актыг хянан баталгаажуулсан байна.

Б.2.4. Захиалагч, зохиогч мэргэжлийн байгууллагын хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүрд нь арилгах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн үү?

Аудитаар 2021 онд хэрэгжүүлсэн ТАХ-г хэрэгжүүлэх явцад захиалагч, зураг төсөв зохиогч, холбогдох мэргэжлийн байгууллагууд хяналт хэрхэн тавьсан, гүйцэтгэгч илэрсэн зөрчил дутагдлыг хугацаанд биелүүлсэн эсэхийг талбайн журнал болон холбогдох бусад баримт материалын хүрээнд үзлээ.

Барилга байгууламжийн, зам талбайн журналд тэмдэглэгдсэнээр ТАХ-ний хэрэгжилтийн явцад давхардсан тоогоор НХОГ, НАЗХГ-ийн хяналтын инженерүүдээс 94 удаагийн, зураг төсөв зохиогч нараас 57 нийт 151 удаагийн үүрэг даалгавар өгчээ. Үүрэг даалгаврын агуулгаас харахад хөдөлмөр хамгааллыг сахиж ажиллах, үе шатны ажлыг технологийн дагуу хугацаанд нь гүйцэтгэх, дутуу болон чанаргүй хийгдсэн ажлыг дахин хийх, үе шатны ажлыг гүйцэтгэж дуусахад актуудыг холбогдох албан тушаалтнуудаар заавал баталгаажуулж байх, сорьц дээж авч лабораторид туршилт хийлгүүлэх зэрэгт чиглэгдсэн байна.

Гүйцэтгэгчдээс өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлснээр ил далд ажлын актыг цаг тухай бүр захиалагч, зохиогч нараар баталгаажуулсан, ажлын гүйцэтгэл, ил болон далд ажлуудыг фото зургаар баталгаажуулж хэвшсэн байна. Мөн графикт ажлыг хугацаанд нь гүйцэтгэх, гэрээнд заасан хугацаанд багтаан дуусах зэрэгт ахиц гарсан байна.

Дүгнэлт: Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-ны хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүрд гүйцэтгэгчээр нь арилгуулах арга хэмжээг авч, тодорхой үр дүнд хүрсэн байна.

Б.3 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт үр дүнтэй байна уу?

ДИТХ-аас баталсан тогтоолд дүүргүүдийн хэмжээнд он дамжих болон шинээр хэрэгжих 235 ТАХ-нд 2021 онд нийт 31,062.1 сая төгрөгийн санхүүжилт олгохоор баталж, гүйцэтгэлээр 33,692.5 сая төгрөг олгосон байна. 2021 онд хэрэгжиж дууссан 141 ТАХ-нээс 18,980.1 сая төгрөгийн өртөг бүхий 126 ТАХ-г хөрөнгийн бүртгэлд бүртгэсэн байна.

Б.3.1. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн, хугацаанд нь бүрэн олгосон уу?

Дүүргүүдийн төсвийн хөрөнгөөр шинэ болон шилжих 235 ТАХ-нд тайлант онд 60,882.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгохоор баталж, гүйцэтгэлээр 175 гүйцэтгэгчид 33,692.5 сая төгрөг буюу 55.3%-ийн санхүүжилт олгожээ.

Харин он дамжин санхүүжих 83 ТАХ-нд тухайн онд санхүүжих 29,820.5 сая төгрөгийг олгохоор баталж, гүйцэтгэлээр 12,007.7 сая төгрөг буюу 40.3%-ийн санхүүжилт олгожээ.

Хүснэгт 15. ТАХ-ний санхүүжилтийн судалгаа

№	Дүүргийн дүн	Өмнөх оноос хэрэгжсэн				2021 онд шинээр хэрэгжсэн				Нийт			
		Санхүүжих		Санхүүжсэн		Санхүүжих		Санхүүжсэн		Санхүүжих		Санхүүжсэн	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	БГД	6	333.7	4	269.1	13	1,978.1	12	1,387.4	19	2,311.8	16	1,656.5
2	БЗД	7	388.3	5	208.2	1	600.0	1	583.1	8	988.3	6	791.3
3	БНД	1	50.0	1	44.8	21	547.1	13	300.7	22	597.1	14	345.5
4	БХД					6	162.1	6	153.5	6	162.1	6	153.5
5	СБД	34	19,873.0	28	5,672.3	44	3,273.5	38	2,679.5	78	23,146.5	66	8,351.8
6	СХД	10	815.7	8	461.9	4	2,398.0	3	1,333.4	14	3,213.7	11	1,795.3
7	ХУД	15	6,590.3	11	5,143.4	25	10,905.9	19	7,743.9	40	17,496.2	30	12,887.3
8	ЧД	10	1,769.5	5	208.0	38	11,197.4	21	7,503.3	48	12,966.9	26	7,711.3
	Нийт	83	29,820.5	62	12,007.7	152	31,062.1	113	21,684.8	235	60,882.6	175	33,692.5

Нийт олгосон 33,692.5 сая төгрөгийн санхүүжилтээс 212.1 сая төгрөгийг дүүргүүд техник хяналтын зардал болон зураг төсөв, магадалшгүй ажил, зохиогчийн хяналтын зардалд зарцуулсан.

Аудитаар 8 дүүргийн Санхүү төрийн сангийн хэлтсээс санхүүжилт олгосон дансны хуулгыг гэрээний хэрэгжилт болон холбогдох баримтуудтай /гэрээ дүгнэсэн протокол, ажлын гүйцэтгэл, ажил хүлээлцсэн актууд/-тай тулган шалгахад ЧД, СХД, СБД-т санхүүжилт олгоходоо бодит ажлын гүйцэтгэлийг үндэслээгүй, өөр эх үүсвэрийн ТАХ-г санхүүжүүлсэн зэрэг зөрчил илэрсэн. Тухайлбал:

- “ЧД-ийн 13-р хороо 56-р цэцэрлэг хэсэгчилсэн засвар”. Гэрээний үнийн дүн 14,3 сая төгрөг. Гүйцэтгэгч: Нью Баян баяр терма ХХК. Шууд гэрээгээр гүйцэтгүүлэх ажлыг эхлээгүй байхад ажил 95%-тай явж байгаа тухай хурлын протокол үйлдэн санхүүжилтийг бүрэн олгуулсан.
- СХД-ийн ОНХС-аас санхүүжих 31,0 сая төгрөгийн 4 ТАХ-г Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтын төсвөөс санхүүжүүлсэн.
- СБД-н “2-р хороо 2-р хороолол ӨЭМТ, цагдаа, хорооны ажлын албаны нэг цэгийн үйлчилгээний байр барих нэмэлт санхүүжилт”. Ажлын гүйцэтгэлээр 58%-ийн санхүүжилт 222.7 сая төгрөг олгогдох байсан ч, 224.0 сая төрөг буюу 1,3 сая төгрөгийг илүү олгосон.

Хэрэгжиж дууссан ТАХ-ний барьцаанд 900.4 сая төгрөгийг төрийн сангийн барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлж, гэрээний үүргээ зөрчсөн 19 гүйцэтгэгчээс гэрээний хугацаа хэтрүүлсэн алдангид 32.0 сая төгрөг суутган тооцож дүүргийн төрийн сангийн дансанд байршуулжээ.

Хүснэгт 16. 2021 онд хэрэгжсэн ТАХ-нд олгосон санхүүжилт барьцаа, алданги

Дүүргүүдийн нэр	Батлагдсан төсөвт өртөг		Олгогдсон санхүүжилт		Барьцаанд		Алданги	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
БГД	19	8,694.6	16	1,656.5	4	23.9	1	1.4
БЗД	8	1,097.7	6	791.2	5	12.1	1	1.0
БНД	22	597.1	14	345.5	6	11.5	0	-
БХД	6	162.1	6	153.5	6	8.1	0	-
СБД	78	25,923.6	58	12,589.2	46	250.2	2	10.2
СХД	14	4,818.4	11	1,795.3	8	29.5	3	2.0
ХУД	44	30,062.2	33	13,518.6	19	312.3	2	3.6
ЧД	60	15,082.6	34	7,945.9	33	252.9	10	13.8
Нийт	251	86,438.3	178	38,795.8	127	900.5	19	32.0

Зөрчил илэрсэн дээрх дүүргүүдийн холбогдох албан тушаалтнуудад албан шаардлага хүргүүлэх, зөрчлийг арилгуулах, хариуцлага тооцох.

Дүгнэлт: Зарим дүүргүүдэд ТАХ-ний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслээгүй олгосон байна.

Б.3.2. Ашиглалтад орсон барилга байгууламж, хүлээн авсан тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг бүртгэлд тусгаж бүрэн хүчин чадлаар нь ашиглаж байна уу?

2021 онд 23,858.2 сая төгрөгийн гэрээний дүнтэй 168 ТАХ бүрэн хэрэгжиж дууссан. Аудитад хамрагдсан 8 дүүргийн хэмжээнд хэрэгжиж дууссан бүртгэлд тусгах шаардлагатай 141 ажлыг хүлээн авч, бүртгэлд тусгасан эсэхийг шалгахад 126 ажил буюу 89.4%-г бүртгэлд тусгаж 15 ажил буюу 10.6% нь бүртгэлд тусгагдаагүй байна. Энэ нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1²⁶-дэх хэсэгт заасныг зөрчжээ.

Хүснэгт 17. Хөрөнгө бүртгэлийн судалгаа

№	Бүрэн хэрэгжиж дууссан ТАХ-ний тоо				Бүртгэлд тусгаагдах						/сая.төг/
	Дүүргүүдийн нэр	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Гэрээний үнийн дүн	Шаардлагатай		Тусгасан		Тусгаагүй		
					ТАХ-ний тоо	Гэрээний үнийн дүн	ТАХ-ний тоо	Гэрээний үнийн дүн	ТАХ-ний тоо	Гэрээний үнийн дүн	
1	БГД	8	940.0	916.1	4	477.5	3	300.6	1	176.9	
2	БЗД	6	841.8	836.8	5	241.8	5	241.8	0	-	
3	БНД	14	367.2	361.8	7	247.3	7	247.3	0	-	
4	БХД	6	162.1	161.8	6	161.6	6	161.6	0	-	
5	СБД	66	8,378.6	8,374.8	57	8,182.2	49	7,240.9	8	941.3	
6	СХД	10	754.5	731.7	10	731.8	10	731.8	0	-	
7	ХУД	23	8,730.2	8,499.3	22	8,493.3	20	7,333.4	2	1,159.9	
8	ЧД	35	4,453.4	3,975.9	30	3,743.4	26	2,722.7	4	1,020.7	
	Нийт	168	24,627.8	23,858.2	141	22,278.9	126	18,980.1	15	3,298.8	

Бүртгэсэн хөрөнгийг төрлөөр ангилбал дүүргийн өмчид 11,683.4 сая төгрөгийн өртөг бүхий 59, ашиглагч байгууллагуудад 7,296.7 сая төгрөгийн өртөг бүхий 67 ТАХ бүртгэж, хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг ашиглаж байна.

Дүгнэлт: 2021 онд хэрэгжиж дууссан 141 ажлаас 126 бүртгэлд тусгажээ.

Б.4 ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ, ЗӨРЧЛИЙГ АРИЛГАСАН УУ?

2020 оны хөрөнгө оруулалтын аудитаар дүүргүүдэд төлөвлөлт, ХАА, захиалагчийн хяналттай холбоотой 5 зөвлөмж, БЗД, БНД, ХУД, СХД, ЧД-үүдэд ХАА-нд 5,270.0 сая төгрөгийн 5, СБД, ЧД-т санхүүжилт илүү шилжүүлсэн 6.2 сая төгрөгийн зөрчил арилгах, нийт 5 албан шаардлагыг тус тус хүргүүлсэн.

Албан шаардлага: Дээрх дүүргүүд нь албан шаардлагын биелэлтийг ирүүлж, хэрэгжүүлж ажилласан.

Хүснэгт 18. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын биелэлт

№	Дүүргийн нэр	Зөвлөмж		Албан шаардлага				/сая.төг/
		Өгсөн тоо	Биелсэн тоо	Өгсөн тоо	Дүн	Биелсэн тоо	Дүн	
2	СХД	5	5	1	764.0	1	764.0	
3	ХУД	5	5	1	1,398.9	1	1,398.9	
4	ЧД	5	5	1	1,351.8	1	1,351.8	
5	БНД	5	5	1	255.0	1	255.0	

²⁶ 9.1. “Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана.”

6	СБД	5	5	1	2.4	1	2.4
	НИЙТ	5	5	6	3,877.3	6	3,877.3

Зөвлөмж: Биелэлтийг дүүргүүдээс ирүүлсэн ч, ХАА зохион байгуулах явцад ТББ болон ТБОНӨХБАҮХАТХ-ийн 14-16 дугаар зүйлийн шаардлагыг хангаагүй гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан, захиалагчийн хяналтыг дутуу хэрэгжүүлсэн, гэрээний биелэлтийг бүрэн хангуулаагүй зэрэг зөрчлүүд дахин давтагдаж гарсан.

Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлж ажилласан ч зөрчил дахин давтагдан гарч байгаа нь эрх бүхий албан тушаалтны удирдлага, ажлын уялдаа холбоогүй байдал, залгамж чанар алдагдсантай холбоотой байна.

Иймд зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлээ.

Дүгнэлт: Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлсэн хэдий ч зөрчил дахин давтагдаж байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитаар илрүүлсэн зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийж байна. Үүнд:

1. Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөхдөө “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Дүүргүүдийн ЗД-ын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” зэрэгт тусгагдаагүй, зураг төсөвгүй ТАХ төлөвлөж батлуулсан.
2. Төлөвлөлтийн шаардлага хангаагүй ажлыг төлөвлөснөөс гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахад хугацаа хойшлогдох, ажил гүйцэтгэх явцад хүндрэл бэрхшээл үүсэх, төлөвлөсөн ажил хэрэгжихгүйд хүрэх зэрэг үр дагаврыг бий болгосон.
3. ХАА зохион байгуулах явцад илэрсэн зөрчил нь ХАА-ны өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг алдагдуулж байна.
4. Захиалагчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй, ажлыг дутуу болон чанаргүй гүйцэтгүүлсэн, чанарын шаардлага хангаагүй, зах зээлийн үнээс хэт өндөр хөрөнгө нийлүүлсэн, зарим техник тоног төхөөрөмж нь ашиглалтын шаардлага хангалтгүй.
5. ТАХ-ний санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн олгож байгаа боловч тухай ажил үйлчилгээ нь чанарын болоод хуулийн шаардлагад нийцсэн эсэхэд анхаарал хандуулахгүй, хугацаа хэтэрсэн гүйцэтгэл дээр алдангийг үнэн бодитоор тооцохгүй байгаа зэрэг нь санхүүгийн сахилга бат сул байгааг харуулж байна.
6. Төлөвлөж, баталсан нийт 275 ТАХ-ний 60.7%-ийг хэрэгжүүлсэн ч шинээр хэрэгжүүлэх 214 ТАХ-ээс 26.7% нь төлөвлөлттэй холбоотой, гүйцэтгэгч сонгон шалгарсан 167 ТАХ-ээс 35.3% нь шаардлага хангаагүй гүйцэтгэгч шалгаруулсан, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн түүвэрт хамрагдсан 145 ТАХ-с 9.0% нь захиалагчийн хяналттай холбоотой аудитын явцад арилгах боломжгүй зөрчил тус тус илэрсэн.
7. ТАХ-ний төлөвлөлт, худалдан авалт, гүйцэтгэлтэй холбоотой зөрчил жил бүр давтагдаж арилахгүй байгаа нь үнэлгээний хороо, захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн байгууллага, албан тушаалтан, ашиглалтад хүлээн авах комисс, хяналт тавьж буй ИТХ, ЗД, төрийн албан тушаалтнууд хууль тогтоомж дүрэм журмыг мөрдөхгүй хариуцсан ажилдаа хайнга, хариуцлагагүй ханддагтай холбоотой байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Дүүргүүдийн ИТХ-д:

1. Хууль тогтоомж, дүрэм журамд заасны дагуу ТАХ-ний төлөвлөлтийг хийж, батлах;
2. Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, 29.5 дах заалтын шаардлага хангасан ТАХ-г төсөл нэг бүрийг бүрэн хэмжээгээр батлах;
3. Хөрөнгө оруулалтын ТАХ-нд хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх.

Дүүргийн Засаг дарга болон худалдан авах ажиллагааны албаны дарга нарт:

1. Хууль тогтоомж, дүрэм журамд заасны дагуу ТАХ-ний төлөвлөлтийг батлуулах;
2. ХАА-ны ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хариуцлагатай байх зарчмыг баримтлан бараа болон ажлын онцлогт тохирсон шалгуур үзүүлэлтүүдийг ТББ-т тусгах;
3. Тендерт оролцогчдоос ирүүлсэн баримт материалыг үнэн зөвөөр үнэлэх, шаардлага хангаагүй гүйцэтгэгч сонгон шалгаруулдаг зөрчлийг таслан зогсоож, үнэлгээний хорооны гишүүдийн үүрэг, хариуцлагыг дээшлүүлж, хууль тогтоомжийг мөрдлөгө болгох;
4. Захиалагчийн хяналтыг хангалтгүй, үр дүн муутай хэрэгжүүлсэн нь төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн, үр өгөөжид муугаар нөлөөлж байгааг анхаарч захиалагчийн хяналтыг эрх бүхий этгээдээр гүйцэтгүүлэх;
5. ТАХ-г чанарын хувьд ашиглалтын шаардлага хангахуйц түвшинд гүйцэтгүүлэх, ажлын тоо хэмжээ дутуу болон чанаргүй хийсэн ажлуудыг гүйцэтгэгчдээр дахин хийлгүүлэх;
6. ТАХ-ний төлөвлөлт, худалдан авалт, гүйцэтгэлтэй холбоотой зөрчил жил бүр давтагдаж арилахгүй байгаад анхаарал хандуулж төлөвлөлт, үнэлгээний хороо, захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн, байгууллага, албан тушаалтан, ашиглалтад хүлээн авах комисс, төрийн албан хаагчдын ажлын хариуцлагыг эрс сайжруулж, албан тушаалтнуудад хариуцлага тооцож, цаашид давтан гаргахгүй байж зөрчлийг таслан зогсоох.

Засаг даргын мөрийн хөтөлбөр, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгаагүй ТАХ
/сая.төг/

№	Дүүргийн нэр	ЗДМХ, ХАХТ-т тусгагдаагүй		Хугацаа	
		ТАХ-ний нэр	Төсөвт өртөг	Эхлэх	Дуусах
1	БГД	Баянгол дүүргийн Цагдаагийн 1 дүгээр хэлтсийн барилгын засварын ажил	170.0	2021	2021
2		Дүүргийн онцгой комисс, онцгой байдлын албаны хэрэгцээнд шаардлагатай авто машин худалдаж авах	100.0	2021	2021
3	СХД	Дүүргийн Тамгын газрын Иргэний танхимыг тохижуулах	70.7	2021	2021
4		Дүүргийн Тамгын газрын Иргэний танхимд шаардлагатай тавилга, тоног төхөөрөмж худалдан авах	56.6	2021	2021
5	ХУД	Цагдаагийн 1, 2 дугаар хэлтсийн байрны фасад, дэвэр засвар	220.0	2021	2021
6		Төрийн байгууллагын хэрэгцээнд үйлчилгээний авто машин худалдан авах	90.0	2021	2021
7		Халуун усны барилгыг цагдаагийн хэсэг болгон засварлах	240.0	2021	2021
8	ЧД	Чингэлтэй дүүргийн Татварын хэлтэст архивын тоног төхөөрөмж, цахим сургалтын камер	40.0	2021	2021
9		Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газар шаардлагатай тоног төхөөрөмж	27.2	2021	2021
10		Чингэлтэй дүүрэг дэх Газар зохион байгуулалтын албанд шаардлагатай тоног төхөөрөмж	40.0	2021	2021
11		Чингэлтэй дүүрэг дэх Цагдаагийн газарт шаардлагатай тоног төхөөрөмж /тусгай зориулалтын техник, хэрэгсэл/	129.0	2021	2021
12		Чингэлтэй дүүрэг дэх Цагдаагийн газарт шаардлагатай тоног төхөөрөмж	50.0	2021	2021
13		Чингэлтэй дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтэст шаардлагатай тоног төхөөрөмж	26.0	2021	2021
14		Чингэлтэй дүүргийн Онцгой комисст автомашин	68.0	2021	2021
15		Цэргийн штабд автомашин	68.0	2021	2021
16		Чингэлтэй дүүргийн Прокурорын газарт суудлын автомашин	40.0	2021	2021
17		Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтэст автомашин	120.0	2021	2021
18		Чингэлтэй дүүрэг дэх Газар зохион байгуулалтын албанд журмын хашаа барих /7 хороо/	58.9	2021	2021
19	Засаг даргын Тамгын газрын фасад засвар	400.0	2021	2021	
20	Засаг даргын Тамгын газрын нэг цэгийн үйлчилгээний засварын ажил	300.0	2021	2021	
21	Авто баазын барилга, тохижилтын ажил	1500.0	2021	2021	
22	БХД	ЗДТГ-ын албан хэрэгцээнд дунд оврын микроавтобус худалдан авах	125	2021	2021
23		Худалдан авах ажиллагааны албанд компьютер, тоног төхөөрөмж нийлүүлэх	10.4	2021	2021
24		Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэст компьютер, тоног төхөөрөмж нийлүүлэх	9.1	2021	2021
25		Дүүргийн төрөлжсөн архивт компьютер, тоног төхөөрөмж нийлүүлэх	3.4	2021	2021
Нийт			3962.3	-	-

Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл-д тусгаагүй ТАХ
/сая.төг/

№	Дүүргийн нэр	Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдаагүй		Хугацаа	
		ТАХ-ний нэр	Төсөвт өртөг	Эхлэх	Дуусах
1	БЗД	Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа, газар ашиглалт болон орчны бохирдолд судалгаа хийх ажил	600.0	2021	2021
2		Баянзүрх дүүргийн өрхийн эрүүл мэндийн төвүүдэд авто машин худалдан авах	225.0	2021	2021
3		Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанд суудлын авто машин худалдан авах	70.0	2021	2021
4		Дүүргийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх зураг төсвийн ажил	150.0	2021	2021
5		Баянзүрх дүүргийн Хүүхэд хамгааллын байр худалдан авах	3,000.0	2021	2021
6	БГД	Усан спорт сургалтын төвийн засвар (7 дугаар хороо)	9.00	2021	2021
7		Баянгол Шинэ өргөө ОНӨААТҮГ-ын хог тээврийн авто машин худалдан авах ажил	750.00	2021	2021
8		Хүүхдийн зуслангийн гадна талбайн тохижилтын ажил	154.00	2021	2021
9		Баянгол дүүргийн Цагдаагийн 1 дүгээр хэлтсийн барилгын засварын ажил	170.00	2021	2021

Дүүргийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

10		Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар, хороодын тохижилт	100.00	2021	2021
11		1-9 дүгээр хороонд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ажлын бэлтгэл ажилд шаардагдах зардал	100.00	2021	2021
12		12-15, 17-20, 24, 25 дугаар хороонд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ажлын бэлтгэл ажилд шаардагдах зардал	100.00	2021	2021
13		Хог тээврийн тусгай зориулалтын авто машин	1,500.00	2021	2021
14		25-н хороо, иргэдэд үйлчлэх төв, дэргэдэх байгууллагуудад тоног төхөөрөмж авах	500.00	2021	2021
15		"Баянгол Агропарк" ОНӨТҮГ-т сургалтын тоног төхөөрөмж худалдан авах	189.90	2021	2021
16		Цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлын зураг, төсөв (Баянгол Агропарк ОНӨТҮГ)	120.00	2021	2021
17		Дүүргийн Онцгой комисс, онцгой байдлын албаны хэрэгцээнд шаардлагатай авто машин худалдан авах	100.00	2021	2021
18		Эрүүл мэндийн төвд шаардлагатай тоног төхөөрөмж	75.00	2021	2021
19	СХД	Амралт цогцолборын газрын барилга	250.00	2021	2021
20		Амралт цогцолборын газарт амралтын байр барих /21-р хороо/	110.00	2021	2021
21	СБД	2 дугаар хороо, 2 дугаар хорооны ӨЭМТ, цагдаа, хорооны ажлын албаны нэг цэгийн үйлчилгээний байр шинээр барих нэмэлт санхүүжилт	384.00	2021	2021
22	ХУД	14 дүгээр хороо, 51 дүгээр цэцэрлэгийн дотор засвар болон галын шатны засвар	158.93	2021	2021
23		Зураг төсөв боловсруулах	394.34	2021	2021
24		13 дугаар хороо 150 дугаар цэцэрлэгийн суурийг хүчитгэх	240.00	2021	2021
25		Цагдаагийн 1, 2 дугаар хэлтсийн байрны фасад, дээвэр засвар /6, 20-р хороо/	220.00	2021	2021
26		Төрийн байгууллагуудын хэрэгцээнд үйлчилгээний авто машин худалдан авах	90.00	2021	2021
27		Зураг төсөв	200.00	2021	2021
Нийт			9,960.2	-	-

Хавсралт 3.

Зураг төсөв боловсруулаагүй батлуулсан ТАХ

/сая.төг/

№	Дүүргийн нэр	Хугацаа		Ангилал	Зураг төсөв хугацаандаа батлуулаагүй болон зураггүй	
		Эхлэх	Дуусах		ТАХ-ний нэр	Төсөвт өртөг
1	БГД	2021	2021	Засвар	Нийтийн зориулалттай орон сууцны дээвэр засварын ажил (1, 4, 13, 14 дүгээр хороо)	181.0
2		2021	2021	Тохижилт	Орчны тохижилт бүхий хог хаягдал ангилан ялгах цэг байгуулах (Нийтийн эзэмшлийн зам талбай)	20.0
3		2021	2021	Тохижилт	Бичил тохижилтын ажил (Үүсмэл хогийн цэг) 9, 21 дүгээр хороо	20.0
4		2021	2021	Засвар	Нийтийн зориулалттай орон сууцны орчны засвар (1, 3, 10 дугаар хороо)	54.0
5		2021	2021	Тохижилт	Хүүхдийн зуслангийн гадна талбайн тохижилтын ажил	154.0
6		2021	2021	Тохижилт	Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар, хороодын тохижилт	100.0
7		2021	2021	Засвар	Нийтийн зориулалттай орон сууцны дээвэр засвар	500.0
8		2021	2021	Гэрэлтүүлэг	Нийтийн эзэмшлийн зам талбайн гэрэлтүүлэг суурилуулах ажил	665.0
9		2021	2021	Тохижилт	Тохижилт, бүтээн байгуулалтын ажил	300.0
10		2021	2021	Тохижилт	Орчны тохижилт (9 дүгээр хороо, 146 дугаар сургууль орчим)	200.0
11		2021	2021	Тохижилт	Орчны тохижилт (21 дүгээр хороо, 278 дугаар цэцэрлэг орчим)	200.0
12		2021	2021	Тохижилт	Авто зогсоол байгуулах (Баянгол Агропарк ОНӨТҮГ)	750.0
13	СБД	2021	2021	Барилга	2 дугаар хороо, 2 дугаар хорооны ӨЭМТ, цагдаа, хорооны ажлын албаны нэг цэгийн үйлчилгээний байр шинээр барих нэмэлт санхүүжилт	384.0
14		2021	2021	Барилга	13 дугаар хороо 150 дугаар цэцэрлэгийн суурийг хүчитгэх	240.0
15	ХУД	2021	2021	Барилга	Цэцэрлэгийн барилга /200 ор/ 15-р хороо	2,400.0
16		2021	2021	Барилга	Цэцэрлэгийн барилга /200 ор/ 16-р хороо	2,400.0
17		2021	2021	Барилга, байгууламж	Яармагийн авто замд явган хүний нүхэн гарц барих /4-р хороо, Хүннү моллын урд талд/	2,000.0
18		2021	2021	Барилга	Хороо, эрүүл мэндийн төвийн цогцолбор барилга /15-р хороо/	1,500.0
19		2021	2021	Барилга	Хороо, эрүүл мэндийн төвийн цогцолбор барилга /21-р хороо/	1,500.0

Дүүргийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

20	2021	2021	Тохижилт	4 дүгээр клиник сувиллын барилгын гадна тохижилт	250.9
21	2021	2021	Засвар	Нийтийн зориулалттай орон сууцны дээвэр засвар /13-р хороо/	42.5
22	2021	2021	Зураг төсөв	Чингисийн хүрээгийн авто замаас Эко ахмадын сувилал хүртэл авто замын зураг, төсөв	55.0
23	2021	2021	Зураг төсөв	Эко зуслангийн зураг төсөл, төсөв	100.0
24	2021	2021	Засвар	Сургуулийн дулааны шугам сүлжээний засвар /18-р сургууль/	40.0
25	2021	2021	Засвар	Сургуулийн дулааны шугам сүлжээний засвар /18-р сургууль/	46.0
26	2021	2021	Тохижилт	Чингэлтэй дүүрэг дэх Газар зохион байгуулалтын албанд журмын хашаа барих /7 хороо/	58.9
27	2021	2021	Засвар	Засаг даргын Тамгын газрын фасад засвар	400.0
28	2021	2021	Засвар	Засаг даргын Тамгын газрын нэг цэгийн үйлчилгээний засварын ажил	300.0
29	2021	2021	Тохижилт	Авто баазын барилга, тохижилтын ажил	1,500.0
30	2021	2021	Тохижилт	Тахилтын амны ойжуулалт, ногоон байгууламжийг үе шаттай нэмэгдүүлэх	46.7
31	2021	2021	Тохижилт	Зуслангийн амуудад соруулдаг бохирын нэгдсэн цооног хийх / 8 ширхэг /	297.3
32	2021	2021	Зам	Хайлаастын замаас Хайлаастын эцэс хүртэл авто зам	976.2
33	2021	2021	Тохижилт	Жижиг дунд үйлдвэрлэл, инновацийн хөгжлийн дэмжих төвийн тохижилтын ажил	79.3
34	2021	2021	Гэрэлтүүлэг	Хайлаастын замаас Хайлаастын эцэс хүртэл авто замын гэрэлтүүлэг	150.0
35	2021	2021	Тохижилт	16 дугаар хорооны Хайрхан Инновац хөгжлийн төв ОНӨТҮГ-ын гадна талбайн хашаажуулах ажил	98.0
36	2021	2021	Засвар	16 дугаар хорооны Хайрхан Инновац хөгжлийн төв ОНӨТҮГ-ын дотор засварын ажил	65.0
37	2021	2021	Зам	17 дугаар хорооны Сурагчийн 24-р гудамж авто зам, чулуун зам тавих	200.0
38	2021	2021	Засвар	1 дүгээр хорооны 12-р байрны фасад засвар	132.0
39	2021	2021	Засвар	2 дугаар хорооны 21-р байрны фасад засвар	175.0
40	2021	2021	Засвар	3 дугаар хорооны 2.40 мянгатын ХХУ-1-30-р байрны фасад засвар	106.0
41	2021	2021	Засвар	4 дүгээр хорооны 54-р байрны фасад засвар	134.0
42	2021	2021	Засвар	5 дугаар хорооны 21-р дүгээр байрны фасад засвар	71.0
43	2021	2021	Засвар	6 дугаар хорооны 31 дугаар байрны фасад засвар	167.0
44	2021	2021	Тохижилт	Мод үржүүлгийн ажил	200.0
45	2021	2021	Засвар	Хороодын барилгын засварын ажил	95.0
46	2021	2021	Засвар	Хороодын сантехник, цахилгаан, бусад засварын ажил	90.0
47	2021	2021	Засвар	15-р хороо 102-р цэцэрлэг гадна талын цэвэр усны шугам, монтаж засвар	15.0
48	2021	2021	Засвар	17-р хороо 174-р цэцэрлэг гадна фасад дотор урсгал засвар	80.0
49	2021	2021	Засвар	7-р хороо 224-р цэцэрлэг урсгал засвар	6.6
50	2021	2021	Тоног төхөөрөмж	18-р хороо 247-р цэцэрлэг агааржуулалт	18.7
51	2021	2021	Засвар	13-р хороо 56-р цэцэрлэг хэсэгчилсэн засвар	15.0
52	2021	2021	Засвар	4-р хороо 9-р цэцэрлэг дээвэр, цахилгаан, сантехник засвар	257.8
53	2021	2021	Засвар	19-р хороо 117-р сургууль фасад, дээвэр засвар	150.0
54	2021	2021	Тохижилт	19-р хороо 117-р сургууль биеийн тамирын талбайн тохижилт	36.8
55	2021	2021	Тохижилт	16-р хороо 139-р сургууль биеийн тамирын талбайн тохижилт	17.9
56	2021	2021	Тохижилт	13-р хороо 17-р сургууль биеийн тамирын талбайн тохижилт	33.6
57	2021	2021	Тохижилт	3-р хороо 24 дүгээр сургууль сагсан бөмбөгийн талбайн тохижилт	81.9
58	2021	2021	Засвар	11-р хороо 57-р сургууль цахилгаан засвар	26.1
59	2021	2021	Тохижилт	11-р хороо 57-р сургууль биеийн тамирын талбайн тохижилт	80.0
60	2021	2021	Засвар	61-р сургууль урсгал засвар	43.2
Нийт	-	-	-	-	20,306.4

Хавсралт 4.

Хөрөнгө оруулалтын шинж чанартай бус ТАХ

/сая.төг/

№	Дүүргийн нэр	Хугацаа		Ангилал	Хөрөнгө оруулалтын шинж чанартай бус ТАХ	
		Эхлэх	Дуусах		ТАХ-ний нэр	Төсөвт өртөг
1	БЗД	2021	2021	Бусад	Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа, газар ашиглалт болон орчны бохирдолд судалгаа хийх ажил	600.0
2	БГД	2021	2021	Засвар	Нийтийн зориулалттай орон сууцны дээвэр засварын ажил (1, 4, 13, 14 дүгээр хороо)	181.0
3		2021	2021	Засвар	Нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шат засварлах ажил (2, 7, 18 дугаар хороо)	116.0
4		2021	2021	Засвар	Нийтийн зориулалттай орон сууцны орчны засвар (1, 3, 10 дугаар хороо)	54.0
5		2021	2021	Засвар	Нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шат солих, шинэчлэлтийн ажил 25 дугаар хороо	120.0
6		2021	2021	Засвар	Нийтийн зориулалттай орон сууцны дээвэр засвар	500.0
7		2021	2021	Засвар	Нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шат шинэчлэл	500.0
8		СБД	2021	2021	Засвар	3 дугаар хороо, 14а дугаар байрны дээвэр засвар
9	2021		2021	Засвар	6 дугаар хороо, 47 дугаар байр гадна фасад засвар	96.5
10	2021		2021	Засвар	7 дугаар хороо, 12б дугаар байрын дээвэр засвар	58.5
11	2021		2021	Засвар	1 дүгээр хороо, 9 дүгээр байрны дээвэр засвар	91.9
12	ХУД	2021	2021	Засвар	Нийтийн зориулалттай орон сууцны засвар	260.0
13		2021	2021	Засвар	Нийтийн зориулалттай орон сууцны засвар, тохижилт, цахилгааны шугам татах	300.0
14		2021	2021	Засвар	Нийтийн зориулалттай орон сууцны дээвэр засвар	42.5
15		2021	2021	Засвар	Нийтийн зориулалттай орон сууцны дээвэр засвар	67.5
16		2021	2021	Засвар	1 дүгээр хорооны 12-р байрны фасад засвар	132.0
17		2021	2021	Засвар	2 дугаар хорооны 21-р байрны фасад засвар	175.0
18	ЧД	2021	2021	Засвар	3 дугаар хорооны 2.40 мянгатын 25-1-30-р байрны фасад засвар	106.0
19		2021	2021	Засвар	4 дүгээр хорооны 54-р байрны фасад засвар	134.0
20		2021	2021	Засвар	5 дугаар хорооны 21-р дүгээр байрны фасад засвар	71.0
21		2021	2021	Засвар	6 дугаар хорооны 31 дугаар байрны фасад засвар	167.0
22		2021	2021	Бусад	ОУБ, иргэд, ААНБ, ТББ-тай хамтын ажиллагаа хэрэгжүүлэх орон нутгийн оролцоо	20.0
Нийт						3,914.7

Хавсралт 5

ХАА зохион байгуулахад үйл ажиллагаатай холбоотой гарсан зөрчил

№	Нэр	ТАХ-ний нэр	Гүйцэтгэгч	Төсөвт өртөг	Тендерийн баримт бичигт тусгагдсан шаардлага хангаагүй
1	БГД ХААА	"Баянгол Шинэ-Өргөө" ОНӨААТҮГ-ын хог тээврийн авто машин худалдан авах ажил	Хьюндай моторс ХХК	750.0	Хуулийн 45.3 дахь заалт "Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээний хувьд тухайн шатны Засаг даргын Тамгын газар захиалагч байна.", Сангийн сайдын 2014 оны 212 дугаар журмын 3.2 дахь заалт "3.2. Үнэлгээний хороо тендерийн баримт бичгийн төслийг боловсруулан захиалагчаар батлуулж, баталгаажсан хувийг тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээдэд тараана" зөрчсөн. Үнэлгээний хорооны гишүүн Ц.Дарханбат нь үнэлгээний хуудсыг бөглөөгүй.
2		Баянгол дүүрэгт цэцэрлэгт хүрээлэн байгуулах тохижилтын ажил 14 дүгээр хороо 15 дугаар байрны	Жавхлан Хүслэн ХХК	120.0	Хуулийн 45.3 дахь заалт "Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээний хувьд тухайн шатны Засаг даргын Тамгын газар захиалагч байна.", Сангийн сайдын 2014 оны 212 дугаар журмын 3.2 дахь заалт "3.2. Үнэлгээний хороо тендерийн баримт бичгийн төслийг боловсруулан захиалагчаар батлуулж, баталгаажсан хувийг тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээдэд тараана" зөрчсөн. Захиалагчийн захирамжгүй худалдан авах ажиллагааг зохион байгуулсан.

Дүүргийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

				Үнэлгээний хорооны гишүүн Ц.Дарханбат нь үнэлгээний хуудсыг бөглөөгүй.
3	Баянгол дүүрэгт цэцэрлэгт хүрээлэн байгуулах тохижилтын ажил 1, 3 дугаар хороо Барс захын хойно	Жавхлан Хүслэн ХХК	180.0	Хуулийн 45.3 дахь заалт "Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээний хувьд тухайн шатны Засаг даргын Тамгын газар захиалагч байна.", Сангийн сайдын 2014 оны 212 дугаар журмын 3.2 дахь заалт "3.2. Үнэлгээний хороо тендерийн баримт бичгийн төслийг боловсруулан захиалагчаар батлуулж, баталгаажсан хувийг тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээдэд тараана" зөрчсөн. Үнэлгээний хорооны гишүүн Ц.Дарханбат нь үнэлгээний хуудсыг бөглөөгүй.
4	Хүүхдийн зуслангийн гадна тохижилтын ажил	Буурал Чандмань ХХК	154.1	Хуулийн 45.3 дахь заалт "Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээний хувьд тухайн шатны Засаг даргын Тамгын газар захиалагч байна.", Сангийн сайдын 2014 оны 212 дугаар журмын 3.2 дахь заалт "3.2. Үнэлгээний хороо тендерийн баримт бичгийн төслийг боловсруулан захиалагчаар батлуулж, баталгаажсан хувийг тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээдэд тараана" зөрчсөн.
5	Баянгол дүүргийн Цагдаагийн нэгдүгээр хэлтсийн барилгын засварын ажил	Хөхгүрэн констракшин ХХК	170.0	Хуулийн 45.3 дахь заалт "Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээний хувьд тухайн шатны Засаг даргын Тамгын газар захиалагч байна.", Сангийн сайдын 2014 оны 212 дугаар журмын 3.2 дахь заалт "3.2. Үнэлгээний хороо тендерийн баримт бичгийн төслийг боловсруулан захиалагчаар батлуулж, баталгаажсан хувийг тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээдэд тараана" зөрчсөн.
6	Орчны тохижилт (21 дүгээр хороо 278 дугаар цэцэрлэг орчим)	Велло-Инк ХХК	200.0	Хуулийн 45.3 дахь заалт "Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээний хувьд тухайн шатны Засаг даргын Тамгын газар захиалагч байна.", Сангийн сайдын 2014 оны 212 дугаар журмын 3.2 дахь заалт "3.2. Үнэлгээний хороо тендерийн баримт бичгийн төслийг боловсруулан захиалагчаар батлуулж, баталгаажсан хувийг тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээдэд тараана" зөрчсөн. Захиалагчийн захирамжгүйгээр ХАА зохион байгуулсан.
7	Тохижилт бүтээн байгуулалтын ажил	Сэрвэн-Овоот ХХК	300.0	Хуулийн 45.3 дахь заалт "Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээний хувьд тухайн шатны Засаг даргын Тамгын газар захиалагч байна.", Сангийн сайдын 2014 оны 212 дугаар журмын 3.2 дахь заалт "3.2. Үнэлгээний хороо тендерийн баримт бичгийн төслийг боловсруулан захиалагчаар батлуулж, баталгаажсан хувийг тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээдэд тараана" зөрчсөн. Захиалагчийн захирамжгүйгээр ХАА зохион байгуулсан
8	Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт тохижилтын ажил		400.0	Үнэлгээний хорооны гишүүн Б.Анудар нь ашиг сонирхлын зөрчилгүйг илэрхийлэх хуудас бөглөөгүй. ТББ гарын үсэг зураагүй. Тендерийг хянан үзээгүй гарын үсэг зураагүй. Үнэлгээний хорооны хурлын тэмдэглэлүүдэд гарын үсэг зураагүй.
9	Нийтийн зориулалттай	Юу Би Жи ХХК	181.0	ТБОНӨХБАҮХАТХ-ийн 45.3 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын эх

Дүүргийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

		орон сууцны дээвэр засварын ажил /1, 4, 13, 14 дүгээр хороо / Багц-1			үүсвэрээр санхүүжүүлэх бараа ажил үйлчилгээний хувьд тухайн шатны Засаг даргын тамгын газар захиалагч байна. Сангийн сайдын 2014 оны 212 дугаар журмын 3.2 дахь заалт Үнэлгээний хороо тендерийн баримт бичгийн төслийг боловсруулан захиалагчаар батлуулж баталгаажсан хувийг тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээдэд тараана. Тус тус зөрчсөн. Үнэлгээний хорооны гишүүн Б.Анудар нь ашиг сонирхлын зөрчилгүйг илэрхийлэх хуудас бөглөөгүй. ТББ гарын үсэг зураагүй. Тендерийг хянан үзээгүй гарын үсэг зураагүй. Үнэлгээний хорооны хурлын тэмдэглэлүүдэд гарын үсэг зураагүй.
10		Орчны тохижилт бүхий хог хаягдал ангилан ялгах цэг байгуулах/Нийтийн эзэмшлийн зам талбай/ багц-2	ЭЭБО ПРОПЕРТИЙЗ ХХК	20.0	ТБОНӨХБАҮХАТХ-ийн 45.3 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлэх бараа ажил үйлчилгээний хувьд тухайн шатны Засаг даргын тамгын газар захиалагч байна. Сангийн сайдын 2014 оны 212 дугаар журмын 3.2 дахь заалт Үнэлгээний хороо тендерийн баримт бичгийн төслийг боловсруулан захиалагчаар батлуулж баталгаажсан хувийг тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээдэд тараана. Тус тус зөрчсөн.
11		Бичил тохижилтын ажил/ Үүсмэл хогийн цэг/ 9, 21 дүгээр хороо Багц-3	ЭЭБО ПРОПЕРТИЙЗ ХХК	20.0	ТБОНӨХБАҮХАТХ-ийн 45.3 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлэх бараа ажил үйлчилгээний хувьд тухайн шатны Засаг даргын тамгын газар захиалагч байна. Сангийн сайдын 2014 оны 212 дугаар журмын 3.2 дахь заалт Үнэлгээний хороо тендерийн баримт бичгийн төслийг боловсруулан захиалагчаар батлуулж баталгаажсан хувийг тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээдэд тараана. Тус тус зөрчсөн.
12		Усан спорт сургалтын төвийн засвар ОНӨТҮГ /7 дугаар хороо/ Багц-6	ГУА-ОРД ХХК	9.0	ТБОНӨХБАҮХАТХ-ийн 45.3 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлэх бараа ажил үйлчилгээний хувьд тухайн шатны Засаг даргын тамгын газар захиалагч байна. Сангийн сайдын 2014 оны 212 дугаар журмын 3.2 дахь заалт Үнэлгээний хороо тендерийн баримт бичгийн төслийг боловсруулан захиалагчаар батлуулж баталгаажсан хувийг тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээдэд тараана. Тус тус зөрчсөн.
13	БЗД ХААА	Дүүргийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх зураг төсвийн ажил	Онч Тэнхлэг ххк	0.2	Тендерийн баримт бичгийг батлуулаагүй. Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 22 дугаар зүйлийн 22.1.Захиалагч тендерийн баримт бичгийг тендерийн урилга нийтлэгдэх өдрөөс өмнө бэлэн болгосон байх үүрэгтэй гэснийг зөрчсөн байна.
14		Баянзүрх дүүргийн өрхийн эрүүл мэндийн төвүүдэд авто машин худалдан авах		0.2	Тендерийг 2021 оны 11 дүгээр сарын 9-нд зарласан боловч шаардлага хангах компани орж ирээгүй тул 2022 оны 2 дугаар сарын 7-нд дахин зарласан, 3 дугаар сарын 10-нд нээнэ.
15		Баянзүрх дүүргийн Хүүхэд хамгааллын байр худалдан авах		3.0	Тус ажлыг 2021.11.09-нд зарласан боловч компани оролцоогүй тул дахин тендер зарласан байна.
16	БНД ХААА	Нийтийн эзэмшлийн явган замын хавтан, эко хавтан, блок үйлдвэрлэх тоног төхөөрөмж худалдан авах	Хэрлэнгийн боргио ХХК	80.0	ДИТХурлаар батлагдсан тогтоол байхгүй. Засаг даргын захирамж байхгүй. Гэрээ байгуулах эрхийг дүүргийн худалдан авах ажиллагааны албанаас хүргүүлсэн.

Дүүргийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

1 7		Тээвэр зохицуулалтын албан ААТҮГ-ын Нийтийн тээврийн үйлчилгээнд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах	Сим ХХК	0.0	Цахим урилга байхгүй. Энэ нь хуулийн 21.1.Захиалагч тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, худалдан авах ажиллагааны цахим систем болон хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ.
1 8		Дүүргийн авто замын засвар шинэчлэлтийн зураг төсөв боловсруулах	Брос Проперти ХХК	0.1	Гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлээгүй. Энэ нь хуулийн 29.1 Захиалагч хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчид гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэж, энэ тухай түүнд болон бусад тендер оролцогч бүрд шалгараагүй үндэслэлийн хамт нэгэн зэрэг бичгээр мэдэгдэнэ гэснийг зөрчсөн байна.
1 9		Энэрэлт-Өлзийн ӨЭМТ, Дүүргийн прокурорын газрын албан хэрэгцээнд авто машин худалдан авах	УАЗ МЕГА ХХК	50.0	Гэрээ байгуулах эрхийг худалдан авах ажиллагааны алба гүйцэтгэгч компанид олгосон..
2 0		19-р хороо, Хуурай мухарт Гал командын зүүн талд иж бүрэн спорт талбайн тохижилт	Цэгц нум ХХК	0.1	Шалгараагүй мэдэгдэл байхгүй.
2 1		16-р хороонд зам засварын ажил	Цэнгийн зам ХХК	0.1	Архивын баримт материалд гэрээ байхгүй.
